

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-28

1.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах/	6-22
2.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах/	22-28

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
9 дүгээр сарын 22-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Батсуурь, Б.Батцэцэг, С.Цэнгүүн, Р.Эрдэнэбүрэн;
Чөлөөтэй: Х.Ганхуяг, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга;
Тасалсан: Х.Баттулга.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Ганмаа, С.Замира нар үг хэлэв.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Энхбаатар, Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн яамны Татварын бодлогын газрын ахлах шинжээч Т.Бат-Оргил, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам, Э.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг танилцуулав.

Нийтийн өргөдөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Л.Мөнхбаясгалан, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн яамны Татварын бодлогын газрын ахлах шинжээч Т.Бат-Оргил, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Б.Пунсалмаа, О.Номинчимэг, Д.Рэгдэл, Б.Бат-Эрдэнэ, С.Замира нар үг хэлэв.

О.Номинчимэг: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжиж, цаашид сайтар судлан хэлэлцүүлж, арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Болорчимэг, Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцов.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг танилцуулав.

Нийтийн өргөдөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийн хэлэлцүүлгийг хойшлуулж, холбогдох сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарыг байлцуулан хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулав./15.59/

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 24 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 18 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. 2025 оны 7 сард Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт орж, Байнгын хороодын бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтыг дахин шинэчилсэн байгаа. Энэ хүрээнд Өргөдлийн байнгын хороог байгуулж, манай Өргөдлийн байнгын хорооны анхны хуралдаан өнөөдөр эхэлж байна. Та бүхэндээ ард иргэдийнхээ дуу хоолой, эрх нь зөрчигдсөн иргэдийнхээ өргөдөл гомдлыг авч үр дүнтэй хэлэлцдэг, энэ Өргөдлийн байнгын хороог амилуулж иргэддээ үйлчлэх энэ үйл хэрэгт хамтран зүтгэнэ гэдэгт найдаж байна.

Өнөөдөр Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдаанд одоогоор нийт 14 гишүүн буюу нийт гишүүдийн 58,3 хувь ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар өнөөдөр ирсэн байна. Жамбын Батсуурь орон нутагт томилолттой, Батмөнхийн Батцэцэг гишүүн гадаадад томилолттой, Саруулсайханы Цэнгүүн гишүүн гадаадад томилолттой, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн орон нутгийн томилолттой, Лувсанжамц гишүүн чөлөө авсан, бусад гишүүд хуралдаанд одоогоор ирээгүй байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 2 хэлэлцэх асуудалтай. 1 дүгээрт, Нийтийн өргөдлийн тухай буюу манай Өргөдлийн байнгын хорооны чиг үүрэгт хамаарч байгаа d.petition дээр гаргасан иргэдээс гарсан нийтийн өргөдөл 2 өргөдлийг хэлэлцэнэ. 1 дүгээрт Монгол Улсын иргэн О.Батхүүгээс ирүүлсэн үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 17 цаг 23 минутад ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байршуулж, 100 мянган иргэний дэмжлэг санал авсан байна.

2 дугаарт Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар Ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийг 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 21 цаг 02 минутад ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байршуулж, 33 мянган иргэний дэмжлэг авсан байна. Энэ 2 асуудлыг өнөөдөр хэлэлцэхээр тов

дараалалд орсон. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Эрдэнэбат гишүүнээр тасалъя. Эрдэнэбат гишүүний микрофон.

С.Эрдэнэбат: Хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлыг дэмжиж байна, нэлээн урт хугацаанд олон саналууд ирсэн. 2 дугаарт энэ ахмадуудаас ийм өргөдөл ирсэн юм. Ахмадууд маань d.petition дээр ахмадууд ороод мэйл хаяг гээд ингээд яг ийм өргөдөл өгөхөд хэцүү шүү дээ. Тэгэхээр энэ ахмадууд яг гараараа ингээд зураад, яг бие биечилж ирсэн энэ та бүгдэд очсон байх. Надад ингээд ирсэн, 7 мянга гаруй өргөдөл гарын үсэг зураад одоо ч ингээд гадаа сууж байгаа. Тийм учраас энэ ахмадуудын цалин, тэтгэвэртэй холбоотой, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой, зээлтэй холбоотой гээд 6 зүйл шаардлага ирүүлсэн байна лээ. Тийм учраас энийг өнөөдрийн хэлэлцэх асуудалд оруулаад, ажлын хэсэг байгуулах ийм юмандаа шуурхайлан орвол яасан юм бэ гэдэг ийм саналыг нэмж оруулж байна.

О.Номинчимэг: Даваасамбуугийн Ганмаа гишүүн микрофон өгье.

Д.Ганмаа: Би харин сая кнопоо дарсан, ажилласангүй. Ер нь Эрдэнэбат гишүүнтэй яг адилхан санал нэгтэй байгаа. Тэтгэврийн асуудлыг нэмэх, инфляцтай уялдуулах, тэгээд энэ зээлийн асуудал, одоо болоод байгаа нөхцөл байдал, тэгээд ахмад настай хүмүүс бие, биеийн байдал ч ямар байгаа билээ, олон маш удаан хугацаанд сууж байгаа. Бид мэднэ шүү дээ зунд сууж л байсан, сая сууж л байна, тарахад сууж л байсан. Энэ асуудлыг заавал Өргөдлийн байнгын хороогоор оруулъя гэсэн саналтай байна.

О.Номинчимэг: Өргөдлийн байнгын хороогоор мэдээж яг энэ ахмадуудын тэтгэвэртэй холбоотой, зээлтэй холбоотой асуудлыг хэлэлцэх нь зөв. Би ч гэсэн санал нэгдэж байна. Бид өдөр болгон л гадаа ахмадуудынхаа дуу хоолойг өргөх гээд ингээд сууж байгаа хүмүүстэй тааралдаж байгаа. Зүгээр өнөөдрийн хувьд нэг дэх өдөр байгаа. Өргөдлийн байнгын хороон дээр яг хэлэлцэх асуудал Даргын дэргэдэх зөвлөлөөр энэ 2 асуудал батлагдсан. Энэний дагуу материал бэлтгэх ажлыг та бүхэнд 5 дахь өдөр тараасан, ажлын хэсэг ч гэсэн энэ хүрээнд ирсэн байгаа. Ахмадуудын энэ тэтгэвэртэй холбоотой өөр бусад энэ асуудлуудтай холбоотой юмыг илүү нягталж хараад, чадвал энэ долоо хоногт үгүй бол дараагийн долоо хоногийн Өргөдлийн байнгын хороогоор яг мэргэжлийн энэ Засгийн газар, яамнуудаас хариуцах хүмүүстэй нь чиглэл чиглэлийг нь гаргаад илүү нарийвчилсан мэдээлэлтэй цөмөөрөө танилцуулга, мэдээллээ авч байгаад хэлэлцье гэсэн ийм саналтай байна.

Даргын дэргэдэх, тийм Даргын дэргэдэх зөвлөл дээр одоо энэ асуудал ороогүй байгаа учраас энэ дээр санал хурааж байж тэн дээрээс ордог учраас яг шууд нэмэлт асуудал оруулахад бид дэгийн хувьд боломжгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг Даргын дэргэдэх зөвлөл дээр миний зүгээс яг тавиад, шуурхай авч хэлэлцэх асуудлаар анхааръя. Тэгэх үү, болж байна уу, гишүүд ээ? Замира гишүүн.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Анхны хурлаа хийх гэж байна манай Байнгын хороо. Тэгэхдээ сая нөгөө гишүүдийн хэлсэн үг нь ортой байна даа. Ахмадууд өлсгөлөн зарлачихсан байна гадаа. Тэгээд бороо хур орж байна настай хүмүүс яадаг бол гэж санаа зовж байна. Тийм учраас яаралтай хэлэлцэх юм уу, эсвэл ахмадуудыг урьж оруулж ирээд энд ярилцаад аль болох хүлээцтэй хандаарай. Одоохондоо ингээд Өргөдлийн байнгын хороо судалж байна гээд хариу өгөх юм уу тийм нэг арга хэмжээ авах нь зүйтэй байх гээд би бодож байна. Тэгээд

өнөөдрийн дэгт оруулж амжихгүй ч гэсэн тийм нэг уулзалт зохион байгуулалт, нэгэнт Өргөдлийн байнгын хороо учраас энэ асуудлыг хэлэлцсэн нь дээр зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Ойлголоо. Энэ дээр, дэгийн дагуу. Тэгэхээр нөгөө дэгийн дагуу бид нэмэлт асуулт одоо шууд нэмэхэд хүндрэлтэй байгаа учраас энэ асуудлыг тавиад, хуваарь дээр боломжтой өдөр Өргөдлийн байнгын хороог хуралдуулах асуудлыг тавья. Тэгээд энэ асуудлыг яг тэр үед хэлэлцье. Тэр үед илүү бэлтгэлтэй, ажлын хэсэг буюу дуудаж мэдээлэл сонсох, мэдээллийг нягтлах энэ нөгөө байгууллагууд маань байж бид илүү үр дүнтэй, ажил хэрэгч хэлэлцүүлэг явуулах учраас энийг илүү гэхдээ шуурхай байдлаар шийдэх асуудал дээр анхааръя гэсэн ийм бодолтой байна. Хэлэлцэх асуудал дээр өөр санал байхгүй тийм ээ. Хэлэлцэх асуудал ингээд батлагдлаа.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах/

1 дүгээр асуудал руу оръё. Нийтийн өргөдлийн тухай Монгол Улсын иргэн Батхүүгээс ирүүлсэн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхэд төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох буюу Хувь хүний орлогын албан татварын тухай тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгох тухай асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын иргэн Отгоны Батсүхээс үл хөдлөх хөрөнгө шилжүүлэхэд төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох буюу Хувь хүний орлогын албан татварын тухай тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгох тухай асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 17 цаг 23 цагт ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын систем d.parliament, d.petition.parliament.mn 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байршуулсан. Тус нийтийн өргөдлийг 2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 100176 иргэн дэмжсэн тул Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.1-д заасан хуулийн төсөл санаачлах саналтай нийтийн өргөдлийг 100 мянга болгон түүнээс дээш тооны иргэн дэмжсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ гэсэн шаардлагыг хангасан байна.

2025 оны 9 дүгээр сарын 15-ны байдлаар дэмжсэн иргэдийн саналын тоо 100306-д хүрсэн байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэсний дагуу Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын Өргөдлийн болон Төсвийн байнгын хороонд хуваарилснаа 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Тус асуудлыг хэлэлцэхэд нийтийн өргөдөлтэй холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажил хариуцсан албан хаагчдыг танилцуулъя. Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Д.Энхбаатар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга, Л.Ичинноров Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга, Д.Сайханчулуун Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын

татварын газрын дарга, Т.Баярмаа Татварын ерөнхий газар, Бүртгэлийн хэлтсийн дарга, Т.Бат-Оргил Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах шинжээч, Ө.Өнөрлхам Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Э.Отгонтунгалаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч нар өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Нийтийн өргөдөлтэй холбогдуулан энэхүү үл хөдлөхийн 2 хувийн татвартай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэрсийн ирцийн дарааллаар С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Үл хөдлөхийн татвартай холбоотой асуудал нэлээн нийгэмд хүлээлт үүсгэсэн байна. Өмнөх Татварын хуулийг 2019 онд хэлэлцэж байхад энэ саналыг тухайн үед ярьж байсан. Тэгээд харамсалтай нь чуулганаар ороод дэмжлэг авч байгаагүй. Энэ хүний өргөдөлтэй холбоотой үл хөдлөх гэдэг нийтлэг байдлаар оруулчихсан байж байгаа. Иргэд ойлгохдоо иргэдийн өөрийн хашаа байшин, орон сууц гэдэг байдлаар ойлгоод байгаа юм. Тэгэхээрээ энэ хүрээнд яг тэр орон сууцтай холбоотой, борлуулалттай холбоотой хэчнээн төгрөгийн татвар цугладаг юм бэ? Энийг аваад дэмжихэд эргээд ямар нөгөө талд нь эдийн засаг юуны сөрөг үр дагаврууд гарах вэ гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт энэ байр орон сууцтай 1, 2, 3, 4 гээд зарим нь ч 10, 60, 70 байртай ч хүмүүс байдаг байх. Ийм хүмүүс ер нь хэчнээн байдаг юм бэ? Магадгүй бид энийг ингээд дэмжихвэл нөгөө талд нь зүгээр үл хөдлөхийн бизнес хийдэг, наймаа хийдэг энэ хүмүүс татвараас зугтах ийм орон зайг нь гаргаад өгчих нэг тийм асуудал нөгөө талд нь яригдаад байх шиг байна лээ. Энэ тал дээр судалсан тооцоо судалгаа байна уу татварынхан?

Нөгөө талаар зарим татварынхан хэлж байсан. 2 хувийг нь больчихвол ашгийн татвар гээд 10 хувь руу нь оруулчих ийм юм гараад ирэх вий гэдэг хүртэл ийм болгоомжлол байгаад байна лээ. Тэгээд тийм нөхцөл байдал яг үүсэх үү, үгүй юү? Ер нь энэ 2 хувийн татварыг анх тогтоохдоо ямар үндэслэл, тооцоо судалгаа хийж байж гаргаж ирсэн юм бэ? Миний хувьд яг энэ 2 хувийн татвартай холбоотой саналыг хэлэхэд тодорхой хэмжээ хязгаартайгаар нь шийдчих боломж бололцоо байхгүй юү? Өөрөөр хэлбэл хувь хүн өөрийн нэг хашаа байшинтай, газартай, хашаа байшингаа зараад байр авахад нь аль алинаас нь худалдаж авч байгаа тал нь ч гэсэн 2 хувийнхаа татварыг нэмнэ, худалдаж байгаа тал нь ч 2 хувийнхаа татварыг нэмнэ гэдэг нийт дүнгээрээ 4 хувийн татварын ачаалал авах гээд байх ийм эрсдэл байдаг. Тийм учраас энэ тал дээр та бүгд энэ асуудал яригдаад нэлээн хугацаа ирсэн учраас татварынхан дээр энийг тодруулж асуумаар байна.

Өөр магадгүй мөнгөн дүн, тэрбумын байшин, хашаа савтай хүмүүс ч байж байгаа house гэх юм уу даа. Нөгөө талаасаа яг ийм 2 хувийн татвар дээр жилдээ хэчнээн төгрөгийн татвар цугладаг юм бэ гэдэг ийм асуултыг асуумаар байна?

О.Номинчимэг: Ажлын хэсэг 4 номер, нэрээ хэлээд, асуултад хариулъя.

Л.Ичинноров: Сайн байна уу? Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров байна. Энэ үл хөдлөхийн борлуулсны 2 хувийн татвар маань анх 1993 он буюу татварын орчин цагийн татварын тогтолцоо бүрэлдсэн үеэс эхлэн

ногдуулж эхэлсэн татвар. Одоог хүртэл 33 жилийн хугацаанд ерөнхийдөө тогтвортойгоор ингээд байгаа энэ хууль байгаад байгаа юм. Ер нь энэ татвар нь жил болгон төлдөг ийм тогтмол ийм татвар биш. Тухайн хүн байр худалдаж аваад, ашиглаад үүний дараа борлуулахад нь буюу хамгийн сүүлийн шатанд нь ноогдож байгаа ийм нэг удаагийн шинж чанартай татвар юм. Энэ тухайн орлого маань өөрөө орон нутаг, тэр дундаа сум, дүүргийн орлого юм. Тэгэхээр энэ нь өөрөөр хэлбэл анхан шатын төрийн үйлчилгээг үзүүлэхэд маш чухал эх үүсвэр болдог гэсэн үг.

Хамгийн сүүлийн байдлаар 2024 оны статистикийг харвал нийт 55 мянга орчим татвар төлөгчөөс 115 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн ийм статистиктай байна. Бид яах вэ олон улсын жишгийг ингээд харж судалж үзсэн. Энэ дээр болохлоор нэг орон сууцын мөчлөг буюу олон улсад татвар байр худалдаж авах үед нь НӨАТ авдаг, амьдран суух буюу эзэмшихэд нь хөрөнгийн татвар авдаг, борлуулах үед нь болохлоор мөн ийм орлогын хөрөнгийн өсөлтийн татвар авдаг тийм жишигтэй. Манай улсын хувьд болохлоор бид ерөнхийдөө иргэдийг орон сууцжуулах бодлогыг дэмжих хүрээнд анх орон сууц худалдаж авахад бид 6 сая төгрөг хүртэлх тийм татварын хөнгөлөлт өгдөг ерөнхийдөө. Тэгээд ямар нэгэн байдлаар амьдран сууж байгаа, эзэмшиж байгаа, орон сууцыг татвараас чөлөөлж, тухайн орон сууцаа зарах, худалдан борлуулах үед нь нийт үнэлгээний 2 хувиар авдаг байгаа.

Өөрөөр хэлбэл бид худалдан борлуулахаас өмнөх үе шат хүртэл бараг барагцаалбал 200 орчим сая төгрөгийн байр худалдаж авсан тэр үед магадгүй 2 жил амьдраад ч юм уу зарчихсан гэж үзье л дээ тэгэнгүүт энийг үл хөдлөхийн татвар буюу 2 хувиас жил бүр ногдуулдаг энэ татвараас бид чөлөөлсөн буюу 8 сая төгрөг, үүн дээр нэмэх нь анх худалдаж авсан төлбөр буюу худалдаж авахад нь өгч байгаа дэмжлэг буюу 6 саяын дэмжлэг, 14 саяын ийм дэмжлэг өгөөд энэхүү байраа худалдах үед нь болохлоор 2 хувийн татвар ерөнхийдөө ногдуулж байгаа гэсэн үг. Харин тухайн байрыг худалдаж авч байгаа иргэн эргээд 6 сая хүртэлх төгрөгийн татварыг ерөнхийдөө дэмжлэг авахаар ийм зохицуулалт байгаа.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Тодорхой хариулаад өгөөч. Би энгийн иргэд үзэж байгаа шүү дээ энэ дээр. Байраа, нэг хашаа байшингаа зарлаа 2 хувийн татвар ноогдуулах нь тийм үү? Дахиад хашаа байшингаа зарангуутаа нэг 1 өрөө байр авлаа 100 сая төгрөгийн ч юм уу, дахиад 2 хувийг нь нөгөө талаас нь худалдаж байгаа хүн чинь 2 хувийнхаа татварыг нэмнэ шүү дээ. Тэгээд нийтдээ нэг хашаа байшингаа зараад нэг өрөө байр авахын тулд 4 хувийн татвар яг тэр хүнд бодитоор тогтоочхоод байна шүү дээ. Тэгээд энэ чинь давхар, давхар татварын ийм юу болоод байна уу гэдэг ийм зүйлийг асууж байгаа? Тэгээд нийтдээ хэдэн төгрөг цугладаг юм, энэ нь өөрөө тийм өндөр ач холбогдолтой иргэдийн татварын ачааллыг бууруулах нэг талдаа, нөгөө талдаа төсөв дээр чинь хэчнээн төгрөг орж ирэх юм бэ? Дүүрэг юун дээр чинь орж ирдэг юм байна шүү дээ.

О.Номинчимэг: 4 номер Ичинноров дарга.

Л.Ичинноров: Сангийн яам Ичинноров. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тухайн хүн амины орон сууцаа зараад, худалдан борлуулах үедээ татвар төлөөд, эргээд байр худалдаж авахдаа 6 сая татвар ямар нэгэн байдлаар татвар төлөхгүй 6 сая хүртэлх хэмжээний тийм татварын дэмжлэг авч байгаа хувь хүний орлогын албан татварын. Тэгэхээр нөгөө 4 хувь гэдэг юм ерөөсөө байхгүй. Энэхүү

орлогоор болохлоор нийт 2024 онд 115 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. Энэ нь болохлоор яг сум, дүүргийн орлогодоо орж байгаа.

О.Номинчимэг: Эрдэнэбат дарга, гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Дараагийн асуух гишүүд ч гэсэн харж байгаа байх. Үгүй ээ би татварын хөнгөлөлт асуугаагүй байна шүү дээ. Тэр 6 хувийн, 6 сая төгрөг чинь тэр анх удаагаа байр авч байгаа нэг цөөн хэдэн хүнд л олгож байгаа юм. Нөгөө талдаа байр худалдаж авахад нөгөө талд нь зарж байгаа хүнд чинь 2 хувийн татвар ороод ирж байгаа шүү дээ. Би энийг хэлээд байгаа юм. Тийм учраас нэг хүн байр авахад анх удаагаа хашаа байшингаа зарж байхад татвар төлнө. Нөгөө талаасаа байр худалдаж авахад зарж байгаа хүнд чинь дахиад 2 хувь ноогдоод байна шүү дээ. Энийг л асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 2 дахь удаагаа байр худалдаж авахад татвар төлөхгүй гэж харагдаж байгаа боловч худалдаж авч байгаа хүн чинь 2 хувийнхаа татварыг байрныхаа үнэ дээрээ нэмээд л өгөх байхгүй юу.

О.Номинчимэг: Юу гээд байна шүү дээ 1, 1 үл хөдлөх ингээд л яваад байх тусам тэгээд 2, 2 хувь ингээд яваад байна шүү дээ. Энэний чинь рационал юу нь юу юм бэ? Ер нь энэ үл хөдлөхийн борлуулалтын 2 хувийн зорилго юу чинь юу юм бэ? Ингээд давхар, давхар шилжүүлэгт орох болгонд 2 хувийн татвар төлөгдөөд байна шүү дээ. Энэ давхар, давхар татварын асуудал биш үү гэдэг асуудлыг тавиад байна. Хэн хариулах вэ? 3 номер Чимидсүрэн дарга, ажлын хэсгийн 3 номер.

Ч.Чимидсүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр энэ Хувь хүний орлогын албан татварын 10.1.1-д энэ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод олсон орлогын нийт дүнгээс нь 2 хувь ноогдуулах ийм зохицуулалттай байгаа юм. Яах вэ түрүүний хэлсэн нөгөө орлогын хувьд 23 онд нийт 28032 иргэнд 56,5 тэрбум, 24 онд бол 31806 иргэний 75 тэрбумын орлого орсон байгаа. Тэгэхээр Хувь хүний орлогын албан татварын энэ орон сууцнаас төлж байгаа энэ 2 хувийн татвар бол сум, дүүргийн энэ төсвийг бүрдүүлдэг ийм татвар байгаа. Түрүүний таны асуугаад хэрэв ингээд эзэмшигч нь өөрчлөгдөөд яваад байгаа л бол тэр болгондоо 2 хувиа нэмж тус тусдаа ингээд тооцож төлөөд л яваад байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл тэр чинь иргэн болгоныхоо хувьд субъект нь өөрчлөгдөөд, татвар төлөгч нь өөр байгаа учраас борлуулалт хийсэн л одоогийн хуулиар тус тусдаа тооцогдоод яваад байна гэсэн үг. Тэгэхээр энийг нэмээд ч юм уу, тэрийг нь давхардлыг нь.../минут дуусав/

О.Номинчимэг: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүний микрофон.

Л.Мөнхбаясгалан: Та хэдийн тоо баримт чинь зөрөөд байна. Бас ямар ч ойлголцгүй байна шүү дээ. Иргэн үл хөдлөх хөрөнгөө зараад 2 хувийн татвар төлдөг, тэрийг алга болгож өгөөч л гэсэн энэ асуудлыг хэлэлцээд байгаа байхгүй юу. Гэтэл 6 сая төгрөгийн иргэн байраа зарчхаад дараа нь тэр иргэн байр худалдаж авахад 6 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлдэг гэж өмнөөс яриад байх юм. Наадах чинь анх удаа байр авч байгаа хүмүүст л эдэлдэг. Тэрнээс биш байраа зараад 2 хувийн татвар төлж байгаа хүн энэнээсээ чөлөөлөгдье гэдэг асуудлыг яриад байгаа байхгүй юу. 110, энэ татвараас улсад 113 тэрбум төгрөг орж ирдэг гээд 50 гаруй мянган иргэнээс гэж Ичинхоролоо гээд та хэлэв үү сая? Та болохоор сая 31 мянган иргэнээс 75 тэрбум гэх юм тоо чинь зөрөөд байгаа байхгүй юу? Тэгээд би асуулт асуугаадахъя.

Энэ асуудлыг үзэл санааных нь хувьд энэ иргэн Батхүүгийн тавьсан энэ асуудлыг олон хүн дэмжээд өнөөдөр Өргөдлийн байнгын хороогоор ярьж байна шүү дээ. Энэ асуудал байж болох уу, 2 хувийн татварыг нь байхгүй болгочихоор ямар нэгэн сөрөг нөлөөлөл буюу том ямар нэгэн гамшиг ч юм уу юм болохгүй биз дээ? Та бүхэн татварынхан энийг нэг хэлээд өгөөч. Тэр тоогоо зөрөөд байгаагийнхаа учрыг олоод өг.

О.Номинчимэг: 3 номер Чимидсүрэн дарга Татварын ерөнхий газар.

Ч.Чимидсүрэн: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тооны хувьд түрүүн нөгөө яамнаас хэлсэн тоо болохоор зэрэг үл хөдлөх хөрөнгийнх нь тоог хэлчхэж байгаа юм. Тэгээд энэ үл хөдлөх хөрөнгө дотор нөгөө газар гэх мэтчилэн бусад тоонд орсон нийт дүнгээрээ хэлчихсэн байна. Миний хэлсэн яг иргэний орон сууцтай холбоотойг нь түрүүн хэлсэн. Өөрөөр хэлбэл 23 онд 56,5, 24 онд 75 тэрбум энэ сум, дүүргийн төсөвт орсон гэсэн санааг хэлж байгаа юм.

Түрүүн Эрдэнэбат гишүүний асуусан асуултад дутуу хариулсан байна. Энэ дээр нэг орон сууцтай иргэн 325820 байна, 2 орон сууцтай иргэний тоо 56582 байна, 3 орон сууц, 3-аас дээш орон сууцтай нь 12376 иргэн байна. Саяын сүүлийн асуултад Сангийн яамнаас хариулна.

О.Номинчимэг: 4 номер Ичинноров дарга. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Л.Ичинноров: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Ичинноров Сангийн яам. Сая энэ тоо баримтыг ерөнхийдөө хэлчихлээ. Энэ орлого нь болохлоор ерөнхийдөө яг сум, дүүргийн ерөнхийдөө төсвийн орлого юм байгаа юм. Тэгэхээрээ энэ нь эргээд ерөнхийдөө сум, дүүргийнхээ анхан шатны төрийн үйлчилгээг үзүүлэхэд ерөнхийдөө яг чухал орлогын эх үүсвэр ерөнхийдөө болдог. Ер нь яах вэ олон улсын жишгээр болохлоор орон сууц анх худалдаж авахад нь ингээд татвар ногдуулдаг НӨАТ-ын татвар ч юм уу, дараа нь амьдран суух буюу эзэмшихэд нь мөн адил ингээд татвар ногдуулдаг. Одоо манайх болохлоор үл хөдлөхийн 2 хүртэл хувийн татвар байгаа. Борлуулахад нь ингээд татвар ногдуулдаг. Гэтэл манайх болохлоор яах вэ өөрийн улсын онцлогт тохируулаад энэхүү үл хөдлөхийг зөвхөн худалдан борлуулах үед нь 2 хувийн татварыг л ерөнхийдөө ногдуулж байгаа, ийм л юм байгаа. Тийм.

О.Номинчимэг: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Жишээ нь байрны ченжүүд гэж хүмүүс байдаг шүү дээ. Энэ хүмүүс үл хөдлөх хөрөнгө орон сууцыг борлуулаад тэгэхээр тэр 2 хувийн татвараас чөлөөлөгдөх нь тэр бизнес хийж байгаа хүмүүст ашигтай болж хувирах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энийг байхгүй болгоод Улсын Их Хурал хэрвээ шийдвэрлэвэл энэ асуудал дээр ямар нэгэн ялгамж тавих уу, тийм юм байгаа юу одоо манай хуульд?

О.Номинчимэг: 4 номер Сангийн яам.

Л.Ичинноров: Энэ нь яах вэ ерөнхийдөө энэ өөрөө үл хөдлөхийн татвар чинь өөрөө нөгөө хөрөнгийн татварынхаа ангилалд ороод явчихна. Энэ дээр болохлоор ерөнхийдөө нөгөө хөрөнгийн бүртгэлийн асуудал аягүй нарийн яригдах ёстой. Хэрвээ нэг иргэн маш олон байр эзэмшээд, тэрнийгээ худалдан борлуулж байгаа

бүртгэл нь хэрвээ гайгүй бол ерөнхийдөө яах вэ энийгээ ялгаж салгах боломжтой. Гэхдээ өнөөгийн байдлаар болохлоор энийг яг одоо энэ ченжийн байр эсвэл тухайн хүн амьдрахаар амьдарч байгаа байраа зарж байна гэдэг нь ялгаж салгах нь нэлээн хүндрэлтэй л болно гэсэн үг.

О.Номинчимэг: Түрүүн Мөнхбаясгалан гишүүн асуусан. Энэ Сангийн яамны Татварын бодлогын газраас хүн байгаа юм уу, байна уу? Энэ татварыг байхгүй болгосноор ямар нэгэн сөрөг үр нөлөө гарах юм уу гэдэг асуулт үлдэгдчих юм. Татварын бодлогоо барьж байгаа Сангийн яамнаас энэ дээр. 5 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Оргил: Сайн байцгаана уу? Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Бат-Оргил. Энэ татварыг байхгүй болгосноор яг ямар үр дагавар вэ гарах вэ гэхээр мэдээж орлогын орон нутгийн орлогын эрсдэл талдаа асуудал үүснэ. Тэгээд дээрээс нь яг энэ татварын дэмжлэг маань нэг зорилтот бүлэгтээ хүрч байх ёстой яг хэнийг дэмжих вэ, яг юуг дэмжих вэ гэдгийг. Бид манай хэлэх гээд байгаа санаа нь болохоор юу вэ гэхээр энэ татварын дэмжлэгийг зарж байхад нь биш яг хүмүүс байраа худалдаж авч байхад нь дэмжлэгийг нь чиглүүлье. Тэр хүн зарахад нь дэмжлэгээ авах биш, нөгөө харин тэр хүнээс худалдаж авч байгаа хүнийг нь дэмжих нь чухал юм гэдэг санааг хэлэх гээд байгаа. Ер нь олон улсад яг ингээд үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой татварын харилцаа 3 үе шатад үүсэж байгаа. Нэг нь худалдаж авахад, нэг нь ашиглаж байхад, нөгөөх нь борлуулж байхад нь. Худалдаж авахад нь бид болохоор Хувь хүний орлогын албан татвараар 6 сая хүртэл, одоо татварын шинэчлэлээр энийг 15 сая төгрөг болгож байгаа. 2 дахь нь болохоор ашиглаж байгаа үед нь бид.../минут дуусав/

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя 5 дугаар микрофон.

Б.Бат-Оргил: Тэр орон сууцаа ашиглаж байгаа үед нь бид чөлөөлөөд өгчхөж байгаа гэсэн үг. Тэгэхээр ерөөсөө олон улсад 3 үе шатад нь авдаг татварыг Монгол Улсад ганц л үе шатад авч байгаа борлуулж байхад нь бид 2 хувиар авч байгаа. Тэгэхдээ тэрийг борлуулж байхад хүн, борлуулж байхад татварт, борлуулж байгаа татвар төлөгчийг дэмжих биш, тэр хүнээс худалдаж авч байгаа татвар төлөгчийг нь дэмжье гэдэг бодлогыг хэлээд байгаа гэсэн үг. Тэр нь зүйтэй гэсэн санаа.

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Сангийн яам, татварынхан маань маш ойлгомжтой л энэ Байнгын хороонд орж ирэх ёстой шүү дээ. Та нар маш ерөнхий ярьж байна. Олон улсад ямар улсад, буурай хөгжилтэй орон юм уу, хөгжиж байгаа орон юм уу, өндөр хөгжчихсөн орон юм уу? Төсөв дээр ямар хэмжээний дарамт үзүүлэх юм бэ, төсөв дээр ямар хэмжээний нөлөөлөл үзүүлэх юм бэ гэхээр ер нь л анхан шатандаа хэцүү л гээд байх юм. Юу нь хэцүү юм энэ чинь тодорхой бус байна. Та хэд, бид жишээлбэл багш нарыг оруулж ирээд юм уу, эсвэл нийгмийн бодлогын ухааны хүмүүсийг оруулж ирээд ерөөсөө яриагүй шүү дээ. Татвар санхүүгийн мэргэжилтэй хүмүүсийг оруулж ирж байгаад та нараас энэ асуудлыг тодруулж ярьж байгаа байхгүй юу. Та нар тоо ярих ёстой. Түрүүн тэнд тоо ярьсангүй. Дээрээс нь 4 номерын микрофон дээр бас л ялгаж тооцоход их хэцүү л гээд л байх шиг байна. Та нарын л хийх ёстой ажил шүү дээ. Та нар хийх ёстой л ажлаа хийх ёстой, тэрнийхээ төлөө цалин авч байгаа.

Бодит тоотой байгаасай л гэж би та бүхнээс хүсэх гэж байгаа юм. Төсөвт яг хэдий хэмжээний энэ 2 хувийн татвар байхгүй болсноор төсөвт яг хэдий хэмжээний татварын төвлөрөлт байхгүй болох юм бэ гэдэг тоог хэлээд өгөөч. Энэ дээр хийсэн тооцоо судалгаа байна уу 1 дүгээр асуудал?

2 дугаарт та хэд орон нутагт нэлээн томоохон хэмжээний анхан шатан дээр томоохон хэмжээний дэмжлэг болдог гэж яриад байх шиг байна. Хэдэн төгрөгийн дэмжлэг болдог юм бэ? Та нар хэдэн төгрөг аваад, хэдэн төгрөг төвлөрүүлээд, тэр хэдэн төгрөгийг хэдэн төгрөгийг нь хуваарилалт хийж өгдөг юм бэ, ямар, ямар зардал гардаг юм бэ, яг энийг тоогоор нь хэлээд өгөөч гэж би хүсэх гэж байгаа юм.

3 дугаарт яах вэ зүгээр зарж байгаа дээр нь дэмжихгүй, худалдан авч байгаа дээр нь дэмжинэ гэж яриад байна. Үгүй ээ тэр хүн байранд, байрыг худалдаж авахдаа та нартай юу ч яриагүй өөрөө мөнгөөрөө авсан шүү дээ, тэр байрандаа амьдарч байгаа шүү дээ. Тэгээд тэр байраа өөрийнхөө тухайн зах зээлийн үнэлгээгээр амьдрал ахуйгаа сайжруулах гээд л зарж, худалдан борлуулаад л явж байгаа шүү дээ. Тэндээс мөнгөн дүн хасагдаж байна гэдэг нь дараагийн байр худалдан авалт дээр хасагдаж орно л гэсэн үг шүү дээ нөгөө талдаа тийм биз дээ? Бид, биш ээ Пунсалмаа гишүүн ээ үгүй биш л дээ. Энэ чинь 2 хувийн чинь татварыг чинь авчихаар би чинь 100 сая төгрөгөөр байр авах гэж байсан хүн 2 хувийг нь татварт өгчихөөр миний 2 дүнгээс 2 хувь чинь хасагдчихдаг юм байгаа биз дээ. Миний 100 сая төгрөгөөс хасагдана биз дээ? Би яагаад 2 хувиа өгөх ёстой юм бэ жишээлбэл ийм л зүйлийг асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр та бүхэн энэ дээр яг тодорхой тоонуудтай, баримтуудтай, факттай нь яг тодорхой хариулаад өгөөч л гэж хүсэж байгаа юм? Баярлалаа.

О.Номинчимэг: 4 номер Сангийн яам Орлогын хэлтсийн дарга Ичинноров.

Л.Ичинноров: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ичинноров Орлогын хэлтэс. Ерөнхийдөө хувь хүн анх удаа орон сууц авсан тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.4-д заасны дагуу 6 сая хүртэлх төгрөгийн буцаалт олгож байгаа. Та нөгөө буцаалт нь хэд вэ, төвлөрүүлдэг орлого нь хэд вэ гээд. Орлого нь ерөнхийдөө 75 тэрбум төгрөгийг 24 онд төвлөрүүлсэн байгаа. Буцаалт нь 80 тэрбум байгаа. Яг ингэж зүгээр жишээ зүгээр авбал анх нэг хүн нөгөө анх 200 сая төгрөгийн үнэлгээтэй байр худалдаж авлаа гэхэд Хувь хүний орлогын албан татварын тухай буцаалт буюу 6 сая хүртэлх төгрөгийн дэмжлэг авна. Магадгүй эзэмшээд 2 жилийн дараа энэхүү байраа зарлаа гэхэд энэ хугацаанд 8 сая төгрөгийн ерөнхийдөө татварын чөлөөлөлтөд эдэлнэ. Тэгээд үүний нийт энэ хугацаанд 14 сая төгрөгийн ерөнхийдөө дэмжлэг авсан гэсэн үг. Ингээд эргээд энэ 200 сая төгрөгийн байраа зарахад 2 хувь буюу 4 сая төгрөгийн ерөнхийдөө татвар төлөхөөр ийм байгаа. Тэгэхээр нийт энэ хүний ерөнхийдөө авсан дэмжлэг, чөлөөлөлт нь өөрөө 14, үүнээс татвар төлсөн 10 гэхээр ерөнхийдөө 10 сая төгрөгийн дэмжлэг авахаар ийм зүгээр жишээ тооцоо байгаа. Тийм. Олон улсын жишээний талаар болохлоор манай Татварын бодлогын мэргэжилтэн хэлнэ.

О.Номинчимэг: 5 номер Сангийн яам Татварын бодлогын.

Б.Бат-Оргил: Олон улсад энэ хөрөнгө борлуулсны орлогыг болохоор 2 төрлөөр татвар ноогдуулж байгаа. Нэг нь болохоор яг тухайн хөрөнгийг худалдаж авсан дүнг нь зарсан дүнгээс нь хасаад gain буюу ашиг дээр нь татвар ноогдуулж байгаа. Нэг нь болохоор нийт дүнгээр, нийт дүн буюу яг Монгол Улсын хэрэглэж байгаа нийт дүн дээр нь татвар ноогдуулж байгаа. Яг ямар улсууд нийт дүн дээр

ноогдуулдаг вэ гэхээр ер нь бүртгэл муутай хөгжингүй улсууд, хөгжиж буй улсууд ерөнхийдөө яг нийт дүнгээс нь татвар ногдуулж байгаа гэсэн үг.

Манай Монгол Улсын хувьд жишээлбэл манай яг Улаанбаатар хотын дийлэнх хувийг бүрдүүлдэг гэр хорооллын хэсгүүд маань жишээлбэл тухайн байрыг бий болгоход ямархуу өртөг гаргасан тэр талаар бүртгэл байдаггүй болохоор манайх 1993 оноос хойшоо энэ хуулийг хэрэгжүүлэхдээ нийт дүнгээс нь 2 хувиар татвар ногдуулаад эхэлсэн гэсэн үг. Хөгжиж буй улсууд яадаг вэ гэхээр, нийт хөгжингүй улсууд яадаг вэ гэхээр нийт тухайн байрыг борлуулсан дүнгээс нь худалдан авахдаа гарсан зардал.../минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер үргэлжлүүлж хариулъя.

Б.Бат-Оргил: Жишээ хэлбэл Грек улс жишээлбэл ашгаас нь 15 хувь, Хорват улс 12 хувь, Гүрж улс жишээлбэл 20 хувиар тооцдог юм байна. Энэ Латви, Серби, Кени энэ тэр гээд ийм улсууд 25 хувиар ноогдуулдаг юм байна. Зарим хөгжингүй улсууд Хувь хүний орлогын албан татварынхаа ерөнхий хувь хэмжээнд нь оруулаад өндөр хувиар ноогдуулдаг. Жишээлбэл Австри 27 хувь, Герман 26 хувь, Франц 30 хувь, Ирланд 33 хувь, Итали 26 хувь гээд ноогдуулдаг. Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмээд хариулахад бид ингээд 2 хувийг зүгээр больчихъё гэдгийг болохоор тухайн татвар төлөгч маань 2 хувиа авахдаа тухайн байрыг худалдаж авахдаа, хамгийн анх тухайн байрыг худалдаж авахдаа 6 саяын дэмжлэгээ авчихсан байгаа гэсэн үг. 6 саяын дэмжлэгээ авчихсан хүнийг дараагийн зарахад нь дэмжих биш, харин дараагийн хүн авахад нь дэмжье.../минут дуусав/

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Төсөвт ямар дарамт үзүүлэх болчихоод байгаа юм бэ гэж би 1 дүгээрт асуугаад байгаа байхгүй юу? Газар орон нутгийн байршил нөлөөлнө наад татвар дээр чинь. Далайд гарцгүй хэдэн орон байдаг билээ. Далайд гарцгүй орнуудын татварын бодлого далайд гарцтай орнуудын бодлого тусдаа дахиад өөр л байгаа. Өнөөдөр Зүүн өмнөд Азийн орнууд усан дээр байшин бариад л амьдарцгааж байгаа шүү дээ. Тэндээс хэдэн хувийн татвар авдаг юм, авдаггүй юм гээд ингээд янз бүр байхгүй юу. Бид өнөөдөр 2 хувьтай холбоотой асуудал дээр Сангийн яам, Татварын ерөнхий газрынхныг хэрвээ татвараас чөлөөлчихдөггүй л юм бол та нар ч гэсэн ялгаагүй л төлнө шүү дээ. Тийм биз дээ? Бид яаж иргэддээ татварын ачаалалгүйгээр явуулах вэ гэдэг бодлогын түвшинд л хариулт гаргаж авах гээд байгаа л хэлбэр. Яаж татвараар иргэдээ дарамтлахгүй байх вэ гэдэгтэй л холбоотой асуудал байхгүй юу. Тэгэхээр 2024 он гэдэг тоо хэллээ. Одоо 25 оны, 26 оны 1 сарын 1-нээс энэ татвар байхгүй боллоо гэж үзвэл хэдий.../минут дуусав/

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? 4 номер Сангийн яам Орлогын хэлтэс Ичинноров дарга.

Л.Ичинноров: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Сая 2024 онд 75 тэрбумаар төвлөрүүлсэн гэж хэлсэн. 2026 оны төсөвт бид 95 тэрбумаар тооцож тусгасан байгаа. Энэ нь болохлоор нөгөө яг түрүүний хэлсэн сум, дүүргийн орлого, орон нутгийн төсвийн орлого, эргээд нөгөө бид орон нутгийн тэнцэл маань нөгөө ашиггүй гарсан тохиолдолд бид нөгөө татаас өгдөг учраас энэ дүн маань ахин 2 дахин үржигдэж төсвийн нөлөөлөл нь орж ирнэ гэсэн үг. Улсын төсвийн нөлөөлөл нь.

О.Номинчимэг: Тэр ялгах боломжтой юм уу хүн өөрөө зарж байна уу, эсвэл дунд нь үл хөдлөхийн зуучлагч эд нар яваад арилжааны шинж чанартай зарагдаж байна уу гэдгийг ялгах боломжтой юу? 3 номер Татварын ерөнхий газар Чимидсүрэн дарга.

Ч.Чимидсүрэн: Энэ нөгөө одоогийн байгаа мэдээ дата, дээр нь нөгөө хууль дээр нөгөө ерөнхий үл хөдлөх хөрөнгө гээд орчихсонтой нарийвчилсан зохицуулалт шаардлагатай холбоотойгоор яг ийм асуултууд ингээд гарч ирээд байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор Татварын ерөнхий газар энэ 25 оны 4 сараас эхлээд нэг etube аппликэйшн хийгээд, өөрөөр хэлбэл татвар төлөгчөө таньж мэдэх, байршилд суурилсан ийм шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлууд хийгдэж байгаа юм. Тэгээд тэр тухайн татвар төлөгчдөө очиж татварын хууль, дүрэм журам, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөн туслах ажил хийх хүрээнд энэ шинэчилсэн бүртгэлийг хийж байгаа юм. Тэгэхдээ зэрэг тэр энэ үр дүнгүүдээс яг энэ хүн цалингаараа амьдардаг юм уу, үйл ажиллагааны орлоготой юм уу, цалинтай болоод дээр нь үйл ажиллагааны орлоготой юм уу гэдэг зүйлүүд нэлээн тодорхой гарч ирэх юм. Тэгээд бид энэ 3 үе шаттай яваад, эхнийх нь ингээд зах худалдааны төв, тэгээд үйлчилгээний байгууллага гээд ингээд бусад чиглэлүүдээр ингээд явах юм. Тэгэхээр энэ дээр нэлээн тодорхой бизнес буюу өөрөөр хэлбэл татвар төлөгчийн таньж мэдэх ажлууд ингээд гараад ирэх юм. Тэгэхээр энэ зүйлүүд.../минут дуусав/

О.Номинчимэг: 3 номер үргэлжлүүлээд хариулъя.

Ч.Чимидсүрэн: Тийм. Тэгэхээр нөгөө хүн яг арилжааны зорилгоор өөрөөр хэлбэл ченж хэлбэрээр бизнесээ орон сууцаа зараад байна уу, эсвэл амьдрахаа зарж байна уу гэдгийг ялгаж чадахгүй байгаа юм. Яах вэ энэ дээр манайхан ингээд энэ асуудал үүссэнээс хойш ингээд Сангийн яаман дээр, татварынхан дээр яриад байгаа зүйлүүд дээр юу гарч байна гэхээр бусад орны туршлага дээрээс нийтлэг харахад яг амьдран суугаад тэр амьдарч, орон сууцдаа юу гэдэг юм 3-аас дээш жил тэр амьдарчихсан бол тэрийг яг өөрийнх нь амьдарч байна гэж үзээд тэрнээс нь хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг практик эсвэл үнийн дүнгийн тодорхой хязгаарлалтууд гардаг тэр практикууд байдаг юм байна лээ. Тэгэхээр бид цаашид ер нь хуульдаа нэлээн сайн тийм нарийвчлан тодорхой зааж өгөхгүй бол үл хөдлөх хөрөнгө борлуулсан гэсэн ингээд ерөнхий үгээр явахаар зэрэг энэний цаана газар ордог, орон сууц ордог, тэгээд энэ хөнгөлөлт дэмжлэгийн бодлогоо хаана уялдуулах вэ гэдэг асуудлыг нарийвчлан зохицуулж өгөх шаардлага байхын хувьд байгаа.

О.Номинчимэг: Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Иргэдийн борлуулж байгаа орон сууцын хэдэн хувь нь гэр бүлийн хэрэгцээнд байгаа орон сууцаа борлуулж орлого олж байна, хэдэн хувь нь олон давтамжтайгаар худалдаж аваад буцааж зараад ашиг олоод явж байна гэдэг асуултыг их олон гишүүд асуугаад сая хамгийн сүүлд нь ийм бүртгэл байхгүй гэж хариулт сонслоо. Тийм болохоор миний хувьд асуултынхаа хариултыг авчихлаа.

Дээрээс нь нэмээд санаа хэлчихье. Тэгэхээр 1 дүгээрт хэдэн хувь нь ашиг олж байгаа болон тогтвортой бизнес юм, хэдэн хувь нь гэр бүлийн хэрэгцээнд борлуулж байгаа юм гэдгийг мэдэж болно. Энэ ажлыг зүгээр бид одоогоор хийгээгүй байна л гэсэн үг. Монгол Улс чинь цахимжилт, бүртгэл дээр муу улс ерөөсөө биш, бүүр хангалттай. Хүн болгоны ИМонголиагаар ороод байж л байгаа бүртгэл нь. Тийм болохоор энэ дээр нэг их шинээр систем үүсгээд, аппликэйшн хийгээд байх

шаардлага байхгүй. Энэ хүрээнд энэ асуудлын хүрээнд ингээд ажлын хэсэг гараад явбал энэ бүртгэлээ ялгаж гаргах шаардлага байна.

2 дугаарт нь манай Сангийн яамныхны энэ чинь мэргэжлийн хүмүүс аргагүй л байх. Гэхдээ өгч байгаа хариулт нь нэг ийм татварын байцаагчийн байр сууриас өгөөд байгаа байхгүй юу. Яг тэр мөнгөө зах дээр юм зарж олсон юм уу, ажил хийж олсон юм уу гээд тэр нь ямар хамаатай юм бэ? Тэгээд эсвэл цагдаа шиг энэ байрандаа 3 жил амьдарсан л бол өөрийн хэрэгцээ гэж үзнэ гээд. Энийг ер нь тогтоох гээд байх хэрэг байхгүй шүү дээ. Ерөнхий зургаар бодлогоор бид хармаар байгаа юм. Монгол Улс ойролцоогоор тал нь дэд бүтцэд холбогдсон орон сууцад амьдарч байгаа хүн амын. Өөрөөр хэлбэл хүний анхдагч суурь хэрэгцээ хангагдаагүй байна. Хүний анхдагч суурь хэрэгцээ хангагдаагүй байхад орон сууцын борлуулалт дээрээс татвар авах нь өөрөө жоохон өрөөсгөл. Хүн ажил хийнэ, цалин авна уу, наймаа хийнэ үү ямар нэгэн байдлаар л тэр хүн чинь мөнгө олоод л тэрэндээ татвар төлж байгаа, нийгмийн даатгалаа төлж байгаа, бүгдийг нь төлж байгаа. Тэгээд тэр мөнгөөрөө анхдагч хэрэгцээгээ хангаж байгаа байхгүй юу. Тэгээд тэр нэг ширхэг байр авахад 6 хувийн 6 сая төгрөг хүртэл дэмжлэг өгч байгаа биш төлөх татвараас нь багасгаж байгаа.

Өөрөөр хэлбэл юм өгөөгүй, авдаг юмаа бууруулж байгаа байхгүй юу энэ бол татварын хөнгөлөлт, дэмжлэг гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ анхдагч хэрэгцээгээ хангаж байгаа юман дээрээс татвар ноогдуулах нь ер нь аягүй их дарамт болж байна л гэж би үзэж байна. Тэгэхээр ангилах хэрэг байна. Ангилалд энэ бол гэр бүлийн хэрэгцээ, энэ олон давтамжтай бизнес. Тэгээд бизнес дээр татвар яаж ноогдуулбал оновчтой зөв байх вэ гэдгийг одоогоор хангалттай цугларчихсан байгаа дата дээр анализ хийгээд, тэгээд энэ эрх зүйн орчныг шинэчлэх талаар санал, дүгнэлт боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Санал нэгтэй байна. Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Ер нь энэ хуулийн төслийг санаачилсан нийтийн энэ санаачилгыг дэмжиж байгаа юм. Тэгээд сая гишүүд маань ер нь бүхлээрээ энэ 2 хувийг ер нь байхгүй болгочихвол төсөв дээр ямар ачаалал үүсэх вэ гэдэг талаас нь асууж байна. Би бол нөгөө талаас нь асуумаар байна. Өнөөдөр манай татварын тогтолцоонд эхэлж байр худалдаж авч байгаа хүнд эргүүлээд хүн амын орлогын албан татвар төлсөн хэмжээнээс нь тооцоод 6 орчим сая төгрөгийг буцаагаад өгч байгаа. Гэхдээ яг энэ аргачлалаар 2 дахь байраа томруулах, нөхцөл сайжруулах нөхцөлд нь үл хөдлөхийн татвар авчхаад эргүүлээд дэмжлэг байдаггүй. Тэгээд 3 дахь, 4 дэх байрт ямар ч дэмжлэг байхгүй татвар, татвар, татвар гэххэж байгаа юм. Тэгэхлээр энэ татвар чинь уг нь иргэд авч байгаа цалингаасаа татвараа төлчхөөд, тэр цалингаасаа эсвэл аж ахуйн нэгжүүд татвар төлсний дараах ашгаараа энэ байрыг авдаг юм шүү дээ.

Тэгэхээр энийг чинь дахиад ингээд 2, 2 хувийн татвар гээд байхлаар энэ давхар татварын ачаалал орж ирээд байгаа байхгүй юу. Энийг ард иргэд хэлээд байгаа юм. Тэгэхлээр энийг нэг байхгүй болгочихно гэхээсээ илүү хүн амын орлогын албан татвар дээр 2 хувийг буцаагаад өгч байхад хүмүүс дуртай байна. Яг энэнтэй ижилхэн тэр 2 дахь байрнаасаа 2 хувийн татвар төлсөн хүнд дахиад шинэ байшингаа авахад нь эргүүлээд хүн амын орлогын албан татвараар буцаагаад эргүүлээд эхний байр авч байгаа шиг 6 сая төгрөгийн дэмжлэг шиг эргүүлж өгөх

боломж байна уу 3 дахь 4 дэх? Энэ талаасаа бид хуулийнхаа боломжийг нэг харж үзвэл яасан юм бэ гэсэн санал.

3 дугаарт нь хүмүүсийн санал, ер нь дурамжхан байгаа зүйл нь энэ татвар чинь юунд зориулагддаг юм бэ? Энэ бол тухайн дүүрэг, орон нутгийн иргэдийн гудамж талбай, гэрэлтүүлэг, сургууль тийм ээ, камержуулалт энэ зүйлд зарцуулагдах ёстой. Гэтэл энэ нөгөө том татварынхаа энэ том pull рүү орж ирээд, тэгээд халамж, тэтгэвэр, тэтгэмж гээд ингээд яваад өгчихлөөр хүмүүс бид энэ татвар төлчөөд энэ хэнд хэрэгтэй юм бэ? Бидэнд эргэж иргэдийн сайн сайханд зориулагдахгүй байна гэдэг энэ зүйлийг яриад байгаа юм. Тэгэхлээр би энэ татварын энэ саналыг энэ гишүүдийн энэ саналуудыг аваад эсвэл бүүр энэ 2 хувийг 2 дахь, 3 дахь байр дээрээс авахгүй байх нэг боломж, эсвэл 2 дахь, 3 дахь байран дээр эргүүлээд байр авах тухай бүрд нь тэр татвар төлж байсан өмнөх үл хөдлөхийн татвар төлсөн иргэдэд нь буцаагаад хүн амын орлогын албан татвар өгөх боломж, цаашлаад иргэдэд ер нь энэ татвараар бид орон нутагтаа юу хийж байгаа юм бэ гэдэг ийм тайлагнадаг ийм систем энэ 3 тал дээр манай Сангийн яам тийм ээ, манай татварын газрынхан ажиллаасай, саналыг бидэнд хүргүүлээсэй гэж хүсэж байна.

О.Номинчимэг: Санал хэллээ. Би бас яг энэ асуудал дээр байр суурийн хувьд энэ иргэдийн 100 мянган хүн гэдэг Монгол Улсын хүн амд харьцуулахад багагүй тоо, маш багагүй тоо. Энэ асуудал өөрөө ер нь энэ ойрын үед татвартай холбоотой асуудлууд олон нийтийн татвар бууруулах асуудал бол олон нийтийн дэмжлэгийг ийм хурдан яагаад авч байна гэдэг дээр Засгийн газар ч гэсэн, энэ татвартай холбоотой ажиллаж байгаа мэргэжлийн байгууллагууд ч гэсэн Улсын Их Хурал бол анхааралдаа авах ёстой. Энэ өөрөө нийгэмд, иргэдэд, ААН-үүдэд татварын дарамт өндөр байна, үнийн өсөлттэй холбоотойгоор бидний өдөр тутмын яг бодит нөгөө орлого маань багасаж байна л гэсэн үг.

Дээр нь татварын шударга бус байдал өндөр байна. Тэгээд эргээд татвар төлдөг энэнийхээ үр шимийг хүртэж чадахгүй байна. Энэний л ерөнхийдөө илрэл гэж харж байгаа. Тэгэхээр энэ асуудлаар Засгийн газар Татварын багц хууль боловсруулж байгаа, боловсруулаад Ипарламент дээр тавьсан гэж ойлгосон. Улсын Их Хурал ч гэсэн энэ дээр уг нь хаврын чуулганы үеэр яггүй л уг нь ажиллаад 5 сард энэ татварын хуулийн шинэчлэлийг оруулна гээд ажилласан. Ингээд хойшлоод байдаг. Ерөөсөө л энэ иргэд дээрээ тулгамдаж байгаа энэ татварын энэ ачааллуудыг давхар, давхар ачаалал байгаа бол үнэхээр бодлогын хувьд энэ нь зөв юм уу, үгүй юм уу гэдгээ маш эргэж харах цаг нь болчихсон гэдгийн маш том дохио гэж үзэж байгаа. Тэгэхээр иргэдийнхээ энэ саналыг дэмжиж байгаа.

Энэ дээр бид яах вэ Дэгийн хуулийн дагуу энэ удаа Өргөдлийн байнгын хороо энэ асуудлыг хэлэлцээд, өөрийн Байнгын хорооны санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн байнгын хороо өөрөө энэ асуудлыг хэлэлцээд арга хэмжээ авах ёстой байгаа. Гэхдээ энэ дээр бид Өргөдлийн байнгын хороо зөвхөн нэг ингээд хэлэлцээд санал, дүгнэлтээ хүргүүлээд орхих биш, хойноос нь энэ асуудал яаж шийдэгдэж байна гэдэг дээр хяналт тавьж, хугацаатай ажиллана. Сар бүрийн сүүлээр бид энэ асуудлууд юу болж байгаа талаар чуулган дээр тайлагнах ийм үүрэгтэй болчихсон байгаа. Тэгэхээр энэ дээр манай гишүүдийн ч хэлж байгаа ер нь санал нэг байна. Манай Монгол Улс орон сууцжуулалтын хувьд ямар нөхцөлтэй байгаа билээ. Агаар, орчны бохирдол гээд бид зөндөө л ярьдаг. Хүмүүсээ орон сууцжуулъя, тохилог, 21 дүгээр зууны эрүүл, аюулгүй орчинд амьдруулъя гэдэг зорилт маань энэ татварын бодлогын хүрээнд хэр байна вэ

гэдгийг сайн дүгнэж, энэ дээр яаралтай нэг арга хэмжээ авах ёстой л гэсэн байр суурьтай байна.

Тэгээд манай энэ өнөөдөр яах вэ Чимэдсүрэн даргаас бусад нь хэлтсийн дарга нарын хэмжээнд, эсвэл ахлах мэргэжилтнүүдийн хэмжээнд ирсэн байна л даа. Ер нь бид хар даа татвар авч байгаа бол энэ чинь ямар ач холбогдолтой, ямар зорилготой татвар юм бэ, төр энэ татвараа хураагаад энийгээ юунд зориулж хийх ёстой юм бэ гэдэг энэ суурь юмнаасаа эхлэхгүй бол төсвийн орлого бүрдүүлэх гэж байгаа юм л гээд байвал буруу шүү дээ. Үл хөдлөхийн хөрөнгийн татвар гэдэг чинь өөрөө уг нь эдийн засгийн маш том ойлголт байгаа. Уг нь энэ 5 номер манай Татварын бодлогын газрын залуу хэлээд л байна л даа. Энэ үл хөдлөх гэдэг юм чинь үнэ цэний хувьд, эдийн засгийн хувьд бид чинь кейнсинг гэдэг юм уу, энэ эдийн засгийн хувьд яаж өсөлт байдаг юм, энэнээс тэр спекуляцаас сэргийлээд үл хөдлөх дээр яагаад татвар тавьдаг юм гэдэг энэ утгаар нь явахгүй. Ерөөсөө л төсөв бүрдүүлэх зорилготой ингээд авдаг юм, тэгээд ингэдэг юм гээд байх юм бол ёстой татварын газрын хувьд ч гэсэн, Сангийн яамны хувьд ч гэсэн бид яах гэж татвар аваад байгаа юм гэдэг чин зорилго цаад учрыг байхгүйгээр механик ажил болчихсон байна л гэсэн үг.

Тэгвэл энэ татвар төлөгчдийн мөнгөөрөө үр шимгүй, тэд нартай үр өгөөжгүй ажил болоод байгаа нь ойлгомжтой биз дээ. Тэгээд яах вэ сая манай гишүүд хэллээ, спекуляц хийгдэх эрсдэл гарах вий дээ, дунд нь ченж хийдэг хүмүүс энийг хөөрөгдөөд, татвар байхгүй болохоор энэ өөрөө цаашаа яалт ч үгүй зах зээлийн зарчмаараа үнийн өсөлт рүү хөтлөх спекуляц хийгдэх, гажуудал руу гарах вий дээ гэдэг асуудлыг хэлж байна. Тэгэхээр энийг яаж хүрээ хязгаарыг нь тогтоож, бүртгэлээ сайжруулж, яг иргэдийнхээ өөрийнхөө орлогоор олоод байшингаа аваад, гэр бүл нь томорлоо, хүүхэд, олон хүүхэдтэй боллоо дахиад дараагийнхаа гэдэг энэ бодлого руу нь зөв чиглүүлж, татварын бодлогоо дарамт болгохгүйгээр явуулах уу гэдэг дээр манай Сангийн яам ч гэсэн, Татварын ерөнхий газар ч гэсэн энэ улсын бүртгэл дээр ч гэсэн энэ бүртгэл тооцоогоо сайжруулах асуудал дээр анхаармаар байна.

Ер нь бараг асуулт гэхээсээ илүү саяын ярианы дунд иймэрхүү л сэтгэгдэл үлдэж байна. Асуудал хөндөгдөж байна. Дахиад асуулт асуугаад ч нарийн бараг тийм хариулт гарахааргүй юм байна гээд би байр сууриа хэлээд үгээ хэлчихлээ. Энэ асуудалтай эхний асуудалтай холбоотойгоор гишүүд асуулт асууж дууссан. Энэ асуудалтай холбоотойгоор гишүүд үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Замира гишүүн, Золжаргал гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Энэ 2 хувийн татвартай та хэдийн сая мэдээллийг аваад энэ чинь бүүр сонин, сонин юм гараад ирлээ. Ерөнхийдөө бид татвараа яг оновчтой ноогдуулж чаддаггүй ерөнхийд нь аваачаад л тавьчихдаг юм байна манай татварынхан. Ашгийн зориулалтаар олон дахин ченж байдлаар зараад байгаа хүмүүсийг ялгадаггүй аваачаад тэгээд л нийтэд нь боломжгүй учраас аваачаад энэ 2 хувийг нь тавьчихъя гээд. Энэ бол нэг талаар бүдүүлэг арга л даа. Нэг талаар би манай Сангийн яам, татварынхан ажлаа хийж чадахгүй байна гэж би харж байна.

2 дугаарт сая гишүүдийн хэлээд байгаа энэ Татварын хуультай холбоотойгоор татварын буцаалт дээрээ анх удаагаа авч байгаа болон эсхүл 60м², 30, 50м² байр байж байгаад тэрийгээ зараад, хүүхэд нь өсөөд, ам бүл нь өсөөд ирэхээрээ 80 юм уу, 90м² авлаа гэж бодъё тэгээд энэ хоёрын хооронд чинь тэр өртгийнх нь зөрөө нь маш тодорхой шүү дээ. Зарж байгаа байр дээр нэмээд зээл

авч байгаа тэр нь бол өртөг байхгүй байхгүй юу хүү юутайгаа. Тэгээд энийг ингээд тооцож чадахгүй энэ тэр гэдэг энэ бол зүгээр маш амархан зүйлийг хийж чадахгүй байна гэж бодож байна. Тийм учраас энэ 2 хувийн татварын үл хөдлөхийг яах вэ нийтэд нь үл хөдлөх гэдэг нэг татвар яваад байгаа тийм үү, энийгээ ангилж үзээд, иргэдийн ихэнх нь 100 мянган, миний хувьд ч гэсэн тэгж бодож байгаа. Орон сууц авах, хашаа байшин байна уу, өөрөө байшингаа барьдаг байна уу ямар ч байсан иргэдэд байраа өөрөө бий болгоод, дараагийнхаа байрыг бий болгоход ихэвчлэн хүмүүс өртөг нэмэгдэж л тэр байр сууцаа сайжруулж байгаа.

Түүнээс биш хашаа байшингаа зарчхангуутаа түүнээсээ доошлуулаад, эсхүл байраа зарчхаад зүгээр хашаа байшин гэдэг ч юм уу ингээд доошлуулж 100 саяар зарчхаад 60 сая төгрөгийнх нь нэг дундаас нь ашиг хийгээд байгаа хувь иргэн гэж байхгүй бараг. Тийм учраас энэ 2 хувийн татвар дээр та бүгд маань хуулийн төсөл дээр маш тодорхой саналууд энэ өргөдлийн 100 мянган хүний саналыг авч үзээд энэ 2 хувийн татварыг ямар хэмжээнд нь хөнгөлөх вэ, хэнд нь хөнгөлж байхгүй болгох вэ, хэнээс нь авдаг байх вэ гэдэг юмаа энэ бол маш амархан гэж би бодож байгаа юм.

Дээрээс нь тэр хэн манай Бат-Эрдэнэ, Пунсалмаа, Золжаргал гишүүдийн хэлээд байгаа тэр буцаалт, татварын буцаалт. Анх удаагаа гэдэг нэг өөр, 2 дахь удаагаа маш олон хүмүүс чинь анх удаагаа хашаа байшин авч байгаа залуу байхдаа 20 насандаа, 30, 40 хүрч ирээд нэг ажил амьдрал бий болоод зээл аваад 40, 50, 60 метр, 80 метр² ч гэдэг юм уу байр авч байгаа. 2 дахь удаад нь боломж олгох тал дээр дэмжих ёстой. Эцсийн дүндээ наад татварын бодлого чинь иргэдийг яавал орон сууцжуулах вэ гэдэг бодлого. Тэр Герман, Орос, Англи, Франц гээд байгаа чинь орон сууцынхаа асуудлыг ерөнхийдөө бараг шийдчихсэн улс. Арай өөр татварын бодлоготой тийм зүйл. Гэтэл бид өөрөө тэрбум тэрбумаар нь зараад ашиг олоод байгаа, нэг байр зарахад 20 саяын зүгээр ашиг нэмээд зарчхаж байгаа агентуудаасаа татвараа сайн авч чадахгүй байгаа мөртөө тэнд нэг хөөрхий орон сууц авах гээд зүдэрч байгаа хүмүүсээс 2 хувийг нь алив авъя гэдэг чинь өөрөө нэг талаар татварын яг оновчтой бодлого биш.

Тийм учраас энэ тал дээр та бүгд маань яг татварын тодорхой саналыг боловсруулж өг. Хэрвээ үгүй гишүүд бид ч гэсэн хууль санаачлах эрх байгаа. Энэ дээр энэ 2 хувийн татвар болон татварын буцаалтын, татварын хөнгөлөлтийг нэмэх асуудал дээр саналууд хамтад нь гаргаад ер нь шийдэх хэрэгтэй юм байна лээ энэ орон сууцын хувь дээр. Нөгөө талаас татварын яг авч чаддаггүй хэсгээ, авч чаддаг хэсгээ бүртгэгдэж байгаа хэсэг дээрээ торгоод байж болохгүй байхгүй юу. Тийм учраас энэ бол өөрөө нийгмийн хамгааллын нэг талын бодлого. Татварынхан мэдээж та бүгд маань татварын байцаагч төсөв л алдчихна гээд байгаа. Тэгээд тэрийг яг нэг дүүрэг дээр гэхэд ямар ачаалал үүрэх юм гэдэг юмыг нь л хуваагаад гаргаад ирэхэд бол тодорхой шүү дээ. Олон дүүрэг, аймагт хуваагаад ирэхээр нэг их шалихгүй л юм байх байх даа. Нэг дүүрэг дээр ганц, хоёр тэрбум төгрөг байна уу, 2, 3 тэрбум байна уу. Хан-Уул мэтчилэн томхон дүүрэг дээр их мөнгө гэхээс илүү бусад нэг их олон дүүрэг дээр нэг тийм татварын цоорхой өм цөм үүсээд л тэрнээсээ илүү нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой гэдэг талаас нь манайхан хараарай.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн үг хэллээ. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Сангийн яам, татварынхан өмнөөс ингэж яриарай гэсэн даалгавартай л юм шиг байна. Цаадуул чинь 2 хувийн татвараас чөлөөлөгдөнө гэдэг асуудлыг ярина. Та нар өмнөөс нь хөнгөлөлт буцаан олголтыг л яриад

байгаарай гэсэн юм шиг тийм юм өмнөөс ингээд яриад байгаа байхгүй юу. Энэ өргөдөл гаргасан иргэн Батхүүтэй 100 хувийн санал нэг байгаа. Хүн байр авлаа. Тэр байрыг өчнөөн жилийн хүүтэй зээл банкнаас аваад, идэх хоолоо, өмсөх зүүхээ хасан, хасан төлж байгаа байхгүй юу. Тэгээд зарна. Зарахдаа заавал томруулах гээд байх, хүн болгон байраа томруулж зарж байгаа юм биш шүү дээ. Зарим нь хүүхдээ гадаадад сургуульд явуулж байгаа тэрэнд мөнгөө төлж байгаа, зарим нь эдгэшгүй хүнд өвчин тусчихсан байгаа тэрний төлөө байр орон сууцаа зарж байгаа. Ер нь тэгээд нэг их баяжаад л, томруулаад л, томруулаад л нэг их зараад байдаг хүмүүс ч байдаггүй л байх гэж би бодож байгаа. Аливаа юмыг туйлшруулахгүйгээр аль аль талаас нь харж бодох ёстой.

Татварын буцаан олголт байж байг. Тэгэхдээ энэ 2 хувийн татвараас чөлөөлөх ёстой гэж бодож байгаа. Олон талаас нь харж үзээсэй. Өнөөдөр байр, иргэн өөрийнхөө байрыг зарж байна уу, эсвэл ченжүүд байр аваад зараад байна уу гэдгийг ялгамж байхгүй гэдэг чинь ёстой үнэхээр гутамшигтай сонсогдож байгаа байхгүй юу. Ойлгомжтой шүү дээ, давтамж байна. Гэхдээ ченж 100 байрыг өөр дээрээ бүртгүүлж байгаад, үл хөдлөх дээр бүртгүүлж байгаад өөрөө буцаагаад зарчихна гэсэн юм бол байхгүй шүү дээ. Тэгэхээр одоо нөгөө байр зарж байгаа иргэдээ чи ченж үү гээд дахиад эрүүдэн шүүдэг тийм юм руу явчих вий дээ.

Тэгэхээр аль аль талаас нь бодлогоо харах ёстой. Тэгээд нөгөө энэрэнгүй хүнлэг байх ёстой, иргэнээ ойлгодог байх ёстой. Тэгээд л иргэний ямар нэгэн иргэнд ашигтай зүйл бариад л ороод ирэхээр татварын юу ихэслээ, улсад эдийн засаг нь бараг л дампуурахаа шахлаа. Энэ чинь болохгүй, төсөвт ийм их эрсдэл үүсэж байна. Тэгвэл энийгээ буцаагаад тэр олох эх үүсвэрийг нь олоод ир гээд ингэдгээ болимоор байна. Энэ бол Засгийн газрын л хийх ёстой ажил. Бид бодлогоо гаргана, шийдвэрээ гаргана, Засгийн газар бодлого гаргана, шийдвэр гаргаж Улсын Их Хуралд оруулж ирнэ, чадна гэж өөрсдөө томилогдсон газар шүү дээ, сайдууд болсон. Тэгэхээр энэ тал дээрээ анхаараарай гэж хэлмээр байна.

О.Номинчимэг: Бат-Эрдэнийн Бат-Өлзий биш ээ, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Харамсалтай сонсогдож байна л даа. Манай татвар, Сангийн яамныхны ярьж байгаагаар бол. Бид анхдагч хэрэгцээг нь хангаж чадахгүй байж ийм асуудал өнөөдөр яриад суугаад баймааргүй л байгаад байгаа юм. Байр гэдэг чинь хүний анхдагч хэрэгцээ байхгүй юу. Тэгээд энэ дээр нь энэ татварын бодлогоор улсын төсөвтэй холбоод, дээрээс нь бид нэгдсэн ангилал байхгүй байна, ерөнхийлөн авч байна гэж хэлээд өнөөдөр хүртэл байж байгаа нь өөрөө аягүй харамсалтай. 100300 гаруй хүний санал гэдэг сонгуулийн насанд хүрсэн буюу 18-аас дээш насанд хүрсэн хүмүүсийн 22 хувь байхгүй юу. Нийт ажил хөдөлмөр эрхлээд орлого олоод, цалин, татвар төлөөд явж байгаа хүмүүсийн чинь хүмүүсийн чинь 22 хувь нь энэ 2 хувийг чинь байхгүй болгоё л гэдэг асуудлыг хөндөөд байна шүү дээ. Тэгээд энийгээ ерөөсөө харахгүй байна. Цоорхой ашиглуулах гэж байгаа юм шиг юм яриад байна нөгөө талдаа.

Би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байсан. Банк бус санхүүгийн байгуулснаас 40 ломбард байгуулаад, санхүүгийн хяналтаас гадна амьдрах нь тухайн ашиг ологчид өндөр байгаа байхгүй юу. Санхүүгийн зохицуулах хороо банк бус санхүүгийн байгууллагуудыг хянадаг та нар өөрсдөө мэдэж байгаа. Гэтэл тэдний хяналтад орохгүйгээр ломбард ажиллуулаад их хэмжээний ашиг олоод, хүүлээд амьдрах нь тухайн ашиг олж байгаа иргэнд аягүй

ашигтай байдаг. Яг тэрэнтэй адилхан сонсогдож байгаа байхгүй юу наадах чинь. Яагаад гэвэл та нар ажлаа хийгээгүй байна, та нар ажлаа хийхгүй байна. Аль хэзээний энийг чинь юу байх вэ дээ энэ чинь 2 сая 238, 40 мянган иргэн л байна. 2 сая 200 хэдхэн мянган иргэнийг үл хөдлөхтэй, хөдөлгөхгүйгээр нь ангилаад, дотор үүссэн ангилал дээр нь хэн нь олон дахин байр аваад байна, хэн нь нэг удаа байр аваад байна, дээрээс нь хэн нь олон дахин олон газар эзэмшил хийгээд, эсвэл өөр хүмүүсийн нэр дээр явуулаад байна, эсвэл хэн нь тэндээ амьдарч байна, амьдрахгүй байна гэдгийг одоо бид ямар 200 сая хүнийг шүүж гаргаж ирэх гэж байгаа биш дээ. Энэ чинь 2-хон сая иргэний л асуудал болчихоод байна шүү дээ.

2 сая гэдэг тоон дотор та нар Сангийн яам, татварын байгууллага тоо бодож чадахгүй бол энэ байгууллагууд цаашдаа яаж оршин тогтнох юм бэ? Төр иргэний төлөө оршдогоос биш, иргэн төрийн төлөө оршдоггүй шүү. Энийг та нар маань их сайн бодож, тунгааж, ажилдаа идэвх зүтгэлтэй, нэг жоохон санаачилгатай ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Анхдагч хэрэгцээ гэдэг зүйлийг бид хангахын төлөө байх ёстой, иргэдээ дэмжих ёстой төр. Өнөөдөр ариун цэврийн байгууламж байна, бие засах газаргүй байна, анхдагч хэрэгцээ шүү дээ хүн бие засна гэдэг, хүн идэж ууна гэдэг анхдагч хэрэгцээ шүү дээ, орон байр гэдэг хүний анхдагч хэрэгцээ шүү дээ. Тэгээд анхдагч хэрэгцээг нь хангах тал дээр төр ажиллаж чадахгүй юм бол төр төр шиг байж чадахгүй байхгүй юу. Тэгээд маш муу байна. Би бол та бүхэнд муу гэдэг дүн тавина. Энд Өргөдлийн байнгын хороон дээр орж ирээд, Улсын Их Хурлын гишүүдтэй тухайн асуултад хариулахдаа мэргэжлийн түвшинд, мэргэшлийн түвшинд хариулах ёстой болохоос биш 6 хувийг бид, 6 сая төгрөгийг бид дэмжлэг үзүүлж байгаа гэдэг ганцхан амны хаалттай орж ирээд, ард түмнээ алгадна гэж бодож байгаа бол тийм юм байхгүй шүү. Бид ард түмнийхээ талд зогсоно шүү.

Батхүү хуульчаас авхуулаад энэ санаачилга гаргаад өнөөдөр ингээд 100 мянга гаруй иргэн ингээд гарын үсгээ цуглуулаад оруулаад ирчихсэн энэ Өргөдлийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, цаашдаа Улсын Их Хурлын түвшинд энэ асуудлыг яриасай гээд явж байгаа байхгүй юу. Урд нь 100 мянга давсан 2 өргөдөл орж ирсэн юм Улсын Их Хурал руу, одоо сураг байхгүй. Яагаад сураггүй болсон гээч яг та нар шиг ингэж хариулдаг учраас энэ өргөдлүүд ард түмний хүсэл сонирхол байхгүй болж байгаа байхгүй юу. Та нар ажлаа хийцгээ.

О.Номинчимэг: Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Баярлалаа. Ямар ч байсан 100 мянган хүн гэдэг маань манай насанд хүрэгчдийн 5 хувь орчим. Тэгэхээр тэд маань ийм санал тавьчихсан учраас Их Хурал дээрээ ч юм уу, Засгийн газар дээрээ аль нэг талдаа иргэнийхээ талд шийдвэр гаргах үүрэг бараг оногдоод байгаа юм л даа. Тэгэхдээ энэ шийдвэрийг зөв гаргах ёстой л гэж бодоод байгаа. Энэ орон сууцаа зараад 2 хувь татвар авдаг эрх зүйн орчин маань 92 онд гэж байх шив дээ бий болсон юм байна. Тэр үед магадгүй энэ үл хөдлөх хөрөнгийн хөдөлгөөнийг сайн бүртгэлжүүлэх агуулгаар энэ татвар оруулсан байж мэднэ. Одоо бол тэр асуудал угаасаа аяндаа бүртгэл энэ тэр явж байгаа учраас энэ учир бол агуулга бол одоо хэрэггүй болчихоод байна гэсэн үг. Тэгээд заавал 2 хувиараа дамжуулж бүртгэдэг.

2 дугаарт ингээд яг практик дээр их, нэлээн олон тохиолдолд энэ хүмүүсийн ярих нь ингээд байр 2 хүн бие биедээ байраа худалдахаар зэрэг юу болж байна гэхээр зэрэг байр худалдан авч байгаа хүн нь 2 хувиа төлөх болдог, хоорондоо

яриад энэ байрныхаа үнийг төдөөр тохироод, худалдаж авч байгаагаараа чи төлөөд гээд энэ тэр ийм агуулгаар их явдаг гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ тэр борлуулж байгаа хүн бол байрныхаа үнийг 2 саяар өндөр зарж байна л гэсэн үг шүү дээ, 2 сая төгрөг, 2 хувиар. Ийм маягтай буруу агуулгаар яваад байдаг нэг ийм тал бий.

Зүгээр яах вэ Их Хурлын тал зүгээс бодож үзэхэд бид ер нь нийт татварын тэр орчин, нөхцөлүүдийг сайн авч үзэж байж сая манай Байнгын хорооны дарга ч хэлчихлээ. Энэ намрын чуулганд энэ татварын эрх зүйн орчныг их өөр хэмжээнд авчирч багцаар нь оруулж ирнэ гээд байгаа шүү дээ. Одоо бол Төсвийн хуулийг дагуулж орж ирж байгаа тэр татвартай холбоотой хуулийн нэмэлт, өөрчлөлт бол жижигхэн өөрчлөлтүүд байна. Тэгээд намрын чуулганд том өөрчлөлтүүд орж ирнэ. Тэр том өөрчлөлтөөрөө энэ 2 хувийнхаа тухай асуудлыг яриад аваад явахад болохгүй гэх юм алга.

Зүгээр Засгийн газрын тал дээр яагаад энэ орон байраа зарсан хүнийг ашигтай бизнес хийгээд 2 хувийн татвар авч байна вэ гэдгээ энэнээс өмнө Их Хуралд маш сайн тайлбарлаж өгмөөр байгаа юм. Би саяын тайлбаруудаас ерөөсөө ойлгосонгүй. Яагаад 2 хувийн татвар авах болчихсон юм бэ гэдэг учир шалтгааныг. Тийм учраас манай Сангийн яамныхан, Татварын ерөнхий газар энэ яагаад татвар авах ёстой вэ гэдгээ нэлээн сайн тайлбарлаж, дараа Төсвийн байнгын хороон дээр очихдоо сайн тайлбарлах шаардлагатай. Ер нь энэ татвар төр яагаад авч байгаа юм бэ гэдэг ойлгомжгүй шүү дээ, надад л лав ойлгомжгүй. Тийм учраас энийг ер нь энэ заалтыг хуулиас хасуулах тал дээр би саналтай байгаа, мэдээж Их хурал шийднэ. Баярлалаа.

О.Номинчимэг: Сонгобайн Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Энэ иргэн Батхүүгийн энэ санаачилсан хуулийг дэмжиж байна. Яагаад гэвэл давхар, давхар ард түмний нуруунд татвар ноогдуулаад байгаа шүү дээ. Тийм учраас энийг дэмжинэ. 100 мянган хүн гарын үсэг зурсан байна энэ бага тоо биш. Гэхдээ Сангийн яамныхан, татварынхан судалгаагаар сайн хийж, энэ татварыг хууль гаргаад, энэ 21 дүгээр, Хүн амын орлогын албан татварын тухай 21 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсгийг хүчингүй болгоход хэр зэрэг төр засаг дээрх, татвар дээрх юу ачаа ямар байдаг юм бэ, тэр нь болохоор байна уу гэдгийг нэг мөсөн энэ судалгаагаар шийдвэрлэж ирэх нь зүйтэй.

Судалгаагаар сайн хийх ёстой. Тэгэхдээ энд нэг татварыг хүчингүй болголоо гээд нэг юм байна бас. Хувь хүн яг өөрийн эзэмшлийн энэ байраа худалдаж байна уу, эсвэл ченжүүд, эсвэл өөр бусад орны хүмүүс байрыг худалдаж аваад, тэгээд тэр нь тэд ингээд татвар ашиглагдаж байна уу гэдэг судалгаагаар сайн хийх хэрэгтэй. Тэгж байж хувь хүн яг өөрийн эзэмшлийн байранд суугаад, тэгээд тэрнийг худалдаж байгаа нөхцөлд тэр татвараас чөлөөлөгдөх учиртай. Энэ бүгдийг нь судалгаагаар сайн хийхийг та бүхнээс хүсэх байна. Хуулиа дэмжиж байна. Энэ хууль санаачлахыг. Тэгээд ажлын хэсэг байгуулагдах байх. Ажлын хэсэг дээр ажиллая.

О.Номинчимэг: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Дэгийн дагуу Өргөдлийн байнгын хороо энийг хэлэлцээд, Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр шийдсэн байгаа. Тэгэхээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгох тухай асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ер нь нийтдээ манай гишүүд энэ 100 мянган иргэд саналаа өгсөн энэ үл хөдлөхийн 2 хувийн татварыг байхгүй болгох, ялангуяа өөрийн амьдарч байгаа арилжааны бус зориулалтаар томсгох нь уу, өөр зорилгоор хувьдаа ингэж үл хөдлөхөө шилжүүлж байгаа энэ нөхцөлд энэ 2 хувийн татварын дарамтыг одоогийн Монгол шиг нөхцөл байдалд байхгүй болгох нь зүйтэй гэсэн нэгдсэн дуу хоолой сонсогдох шиг боллоо. Энэ дээр мэдээж Сангийн яам, татварынхан маань маш анхааралтай сайн ажиллаж энэ татварын багц хуульдаа одоо боловсруулж байгаа хуульдаа бараг энийгээ судлаад, тэр ялгах ёстой бүртгэл байдаг юм уу, зах зээлд гаргах сөрөг нөлөөлөл спекуляцыг яаж багасгах вэ гэдэг дээр хөшүүргүүдийг нь одоогоос судалж байх хэрэгтэй болов уу. Энэ бол ард иргэдийн дуу хоолой гэдгийг та бүхэн ч гэсэн ойлгож байгаа байх.

Тэгээд Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн манайд чинь Төсвийн байнгын хороонд байдаг гишүүн хэн байгаа билээ? Хассуурийн Ганхуяг гишүүн өөрөө Төсвийн байнгын хорооны дарга байдаг юм байна. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё. 2 дугаар асуудал Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар Ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хэлэлцье. Санал дүгнэлт л байгаа шүү дээ. Тэгвэл гишүүд ээ ингэвэл яаж байна. 2 Байнгын хороогоор хэлэлцэгдэнэ. Бид санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр заасан байгаа. Тэгэхээр энэ асуудлын хүрээнд дараах томъёоллоор санал хураах гэсэн саналтай байна.

Иргэн Батхүүгийн гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжин, сайтар судалсны үндсэн дээр цаашид хэлэлцэн арга хэмжээ авах гэдэг дээр дэмжинэ, дэмжихгүй гэсэн саналаар. Сая гишүүд маань ерөнхийдөө байр сууриа илэрхийлчихлээ. Гэхдээ сөрөг үр нөлөөлөл чинь юу байх юм бэ, нарийвчилж энийгээ нэг хараад энийгээ ялгах тэр бүртгэлээ нэг сайжруулаач гэдэг саналуудыг хэллээ шүү дээ. Тэгэхээр зарчмын хувьд дэмжээд, цаашид энэ асуудлыг сайтар судалж, үргэлжлүүлэн хэлэлцэж арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураах уу? Санал хураалт. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. Саяын хэлсэн нийтийн өргөдлийг зарчмын хувьд дэмжиж, цаашид сайтар судлан хэлэлцүүлж, арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад, 16 гишүүн санал хураалтад оролцсоноос, Пунсалмаа гишүүн дэмжсэнээр бүртгүүлье гэж байна. Нийт 13 гишүүн дэмжсэнээр санал хураалт дэмжигдлээ.

Энэхүү санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд, Төсвийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

15.32 цаг

Хоёр.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах/

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь асуудал нийтийн өргөдлийн тухай Монгол Улсын иргэн Б.Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын иргэн Батсайханы Номингоос ирүүлсэн эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар Ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийг 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 21 цаг 02 минутад ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байршуулсан. Тус нийтийн өргөдлийг 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 33083 иргэн дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.3-д заасан тодорхой асуудлаар Ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол Улсын Их Хурал авч хэлэлцэнэ гэсэн шаардлагыг хангасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэсний дагуу Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын Өргөдлийн, Төсвийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилснаа 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Тус нийтийн өргөдөлтэй холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажил хариуцсан албан хаагчдыг танилцуулъя. Б.Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Т.Болорчимэг Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч, Э.Адьяасүрэн Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга эдгээр албан тушаалтнууд ирсэн байна. Ер нь цаашид иймэрхүү одоо яг төсөв хэлэлцэж байгаа ийм асуудал дээр төсөвтэй холбоотой албан тушаалтнуудыг оруулж байх нь зүйтэй гэж тэмдэглэе.

Энэ нийтийн өргөдөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд эхлээд нэрсээ өгнө үү? Галбадрах гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Энэ дээр иргэдээс d.petition дээр санал өгөхөөс гадна олон газраас санал ирсэн. Би энийг хэлье. Боловсролын салбар гэхэд Боловсролын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний холбооноос гээд бараг 70 мянган гишүүнтэй ийм газар байдаг Цогтгэрэл гээд даргаас ирсэн байна. Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлээс мөн цалин нэмэгдүүл. Хоёулаа ер нь 3 сая 500 болго гэдэг ийм саналыг ирүүлсэн. Дорноговь аймгийн үйлдвэрчний эвлэл, Хөвсгөл, Орхон, Булган, Дорнод энэ тэр гээд ингээд үйлдвэрчний эвлэлүүдээс маш их өргөдөл ирсэн. Тэгэхээр энэ төсөв хэлэлцэж байгаатай холбоотойгоор яг энэ төсвийн боломж дээр яг Сангийн яамнаас хэдэн төгрөгийг энэ боловсрол, эрүүл мэндийн салбарт цалин нэмэгдүүлье гээд тавьчихсан юм бэ гэдгийг тодруулж асуумаар байна?

2 дугаарт эрүүл мэндийн салбарыг гүйцэтгэлийн үнэлгээ гээд ингээд орхичхоод байгаа. Яг үнэндээ хэлэхээр төсөв дээр харж байхад тэр гүйцэтгэлийн үнэлгээний сан дээр нь мөнгө нэмж тавиагүй байна лээ. Тэгэхээр үндсэндээ эм,

тариа, мэс заслын хэрэгсэл, ашиглалтын зардлаа өгчхөөд, цалингаа нэмэх боломжийг нь тавихгүйгээр цалингаа дотроо зохицуулаад нэм гэдэг байдал маань үндсэндээ бол бараг үгүй гэж хэлж байгаатай бараг ойролцоо л доо 1 дүгээрт.

Хоёрдугаарх нь яг энэ төсвийн хэлэлцүүлгийн үеэр магадгүй энэ 2 салбарын үйлдвэрчний эвлэл, ялангуяа боловсролын үйлдвэрчний эвлэлийн байгууллага энэ тэр ингээд хамтын маргаан үүсгэчихсэн байна лээ. Ажил хаялт руу бүүр тулчихсан. Хамтын хэлэлцээр дээрээ 3 сая 500 хүртэл болгоно, улсын дунджаас дээшээ болгоно энэ тэр гээд тавьчихсан. Тийм учраас энэ тал дээр яг Сангийн яамныхан ямар төсөв, төлөвлөгөөнүүд тавьсан байна.

Хөдөлмөрийн яамныхан нийтэд нь л авч үзнэ, авч үзвэл нийтэд нь л авч үзнэ гэдэг нэг ийм байр суурь бариад суугаад байгаа юм. Яах вэ ер нь тийм зарчим боловч яг зарим салбар дээр онцгойлон авч үзэхгүй бол болохгүй байна. Яах гэж тухайн салбарын жил гэж зарладаг юм. Тийм учраас энэ цалин хөлстэй холбоотой энэ асуудал дээр нь онцгойлон авч үзээч. Тэгэхгүй бол яг үнэндээ багш нар, эмч нартайгаа бид тухайлбал бид барьцаад суугаад баймааргүй байна. Төрийн өөр зарим захиргааны ч гэдэг юм уу, өндөр ажил, албан тушаалтай, эсхүл өөр арай өндөр үнэлгээтэй байгаа хүмүүс нь энэ удаадаа хойш нь сууна ч гэдэг юм уу. Тийм учраас энэ талаар Хөдөлмөрийн яам ямар байр суурьтай байна вэ? Тэр 3 талт хэлэлцээр энэ тэрээ хийж байгаа юм уу, үгүй юм уу? Энэ төсөв хэлэлцэхээс өмнө энэ үйлдвэрчний эвлэлүүдтэйгээ учраагаа олсон уу, үгүй юу, уулзсан уу? Тэгэхгүйгээр ингээд 2 талд маргаан үүсгэхээд ингээд яг төсөв хэлэлцэх шатад ямар ч арга хэмжээ байхгүй, нэг жагсаал цуглаан, ажил хаялт, тэмцэл рүү нь түлхээд суугаад байж болохгүй. Тийм учраас энэ тал дээр яг ямар явцтай байж байгаа вэ гэдэг талаар асуумаар байна?

О.Номинчимэг: Нэлээн хэдэн асуулт байна, хэн эхэлж хариулах вэ? Төсөв, Сангийн яам хариулах уу? Ажлын хэсэг 6 номер, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2026 оны төсвийн төслийг Засгийн газар дээр боловсруулахдаа төрийн албан хаагчдын цалин хөлсийг 26 ондоо нэмэхгүй гэдэг байдлаар төсвийн төслийг боловсруулсан. Тийм учраас эрүүл мэндийн салбар дээр ч тэр, боловсролын салбар дээр ч тэр яг масс байдлаар бүх төрийн албан хаагчдын үндсэн цалин болон түүнээс хувиар бодогддог нэмэгдлүүдийг нэмэхгүй ийм зохицуулалттай төсвийн төсөлд тусаад орж ирсэн.

Боловсролын салбар дээр бол гэхдээ энэ нийслэл дэх ачаалал ихтэй ажилладаг багш нарын хувьд асуудлыг арай өөрөөр авч үзье гэдэг бодлого Засгийн газар дээр яригдсан. Энэ дагуу ЕБС, СӨБ-ын хувьсах зардлыг 100 тэрбумаар нэмэгдүүлсэн ийм дүн төсвийн төсөлд туссан байгаа. Энэ хувьсах зардлыг энэ илүү их ачаалал ихтэй хэсэг рүүгээ илүү чиглүүлэх, тэдэнд илүү их энэ ачаалалтай нь уялдсан байдлаар мөнгө төгрөгийг нь, цалинг нь нэмэгдүүлэх ийм зохицуулалт хийгдэнэ. Төсөв батлагдсаны дараагаар нарийвчилсан байдлаар энэ үйл ажиллагаа маань хийгдэнэ. Энэ Засгийн газар дээрээ яригдаад.

Эрүүл мэндийн салбарын хувьд бол Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал болон яг улсын төсвөөс энэ эрүүл мэндийн салбарт зарцуулдаг төсвийн хэмжээ бол 2025 оны түвшиндээ байгаа. Энэ бол манай нийт төсвийн нийт зарлага, тэгээд энэ орлогын боломждоо таарсан байдлаар бид төсвийг тусгаж орж ирсэн.

2025 оны хувьд уул нь энэ оны эхэнд нөгөө ковидын үеийн нэг он дамжиж, 2, 3 жил дамжсан өрийг барагдуулаад, тэгээд энэ ондоо даатгалын сан өргүй гарахаар бид ингэж тооцож 25 оны төсвийг хийсэн. Яг энэ дээр суурилсан 26 оны төсвийн төсөл явчихаар бид уг нь энэ нь эргээд эрүүл мэндийн салбар дээр тодорхой хэмжээний ийм нэмэлт эх үүсвэр гарна гэж тооцож байсан.

Гэтэл 25 оны төсөв хэрэгжих явцад ЭМД-ын сан дээр тоо хэмжээний болон зарим нэг ийм гэрээлэлтээр хэтрүүлснээс болоод энэ өр маань ингээд даамжраад үүсээд яваад байгаа. 26 оны төсөв маань тэгэхээр яг энэ 25 оны түвшиндээ явна гэсэн үг. Тэгэхдээ яг амьдрал дээр эрүүл мэндийн салбар дээр цалин хөлс маань яаж явж байна гэхээр ер нь дийлэнх нь 10-аас дээш жил, 10 хавьцаа жил ажилласан эмч нар масс байдаг салбарын хэмжээнд. Яг үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон илүү цаг, нөхөх төлбөрийг оруулаад яг улсын хэмжээнд эмч нарын цалин маань энэ Сангийн яаман дээр нэгдсэн байдлаар хөтлөөд явдаг цалингийн системийн энэ датагаас харахад ойролцоогоор 3,6-аас 4 саяын түвшинд байдаг юм 10-аад жил ажилласан багш нарын хувьд. Тэгэхээр энэ дээр ер нь 3,6 сая төгрөг гэдэг чинь 1 мянган доллар хавьцаа гэж ойлгож болно. Эмч нарын цалингийн хувьд ийм байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн тодруулъя. Түрүүн нөгөө нэлээн их асуулт асуусан. 4 номер Алимаа дарга.

Б.Алимаа: Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлогын газрын дарга Алимаа гишүүний асуултад хариулъя. Ер нь Засгийн газраас 23-аас эхлээд, 23 оноос эхлээд төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудлаар нэлээн олон арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж ирсэн. Энэ дотор орон нутгийн нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн. 5 жил тутам, 6 сарын тэтгэмж олгох, цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулаад нэмэх гэх мэтчилний нийтлэг арга хэмжээ нэлээн олон авч хэрэгжүүлсэн.

Одоогийн байдлаар Статистикийн хорооны 25 оны 1 дүгээр улирлын статистик мэдээгээр боловсролын салбарын ажиллагсдын дундаж цалин 2,4 сая орчим байгаа. Энэ нь нөгөө төрийн үйлчилгээний болон багшлах, багш бусад ажилтны нийт салбарын хэмжээний цалингийн дундаж гэж хэлж болно. Эрүүл мэндийн салбарын хувьд 2,4 сая төгрөг гэсэн ийм статистикууд гарсан байна. Энэ 26 оны төсвийн төсөлд Сангийн яам түрүүн хэлчихлээ. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг.../минут дуусав/

О.Номинчимэг: Үргэлжлүүлэн хариулъя, 4 номер ажлын хэсэг.

Б.Алимаа: Тодорхой төсөв тавьж орж ирээгүй. Боловсролын яам, Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ багш нарын цалинтай холбоотойгоор хамтарсан ажлын хэсэг ажиллаад 8 сарын 31-ний өдрөөр ажлын хэсгийн дүгнэлтээ гаргачихсан. Нийтдээ улсын хэмжээнд 8 мянга гаруй анги дүүргэлт 35-аас дээш сурагч суралцдаг бүлгийн ачааллыг тооцсон, ачаалалтай холбоотой нэмэгдэл хөлс тооцох асуудлаар энэ цалин хөлсний бүрэлдэхүүн дээр өөрчлөлт оруулах байдлаар нэгдсэн ажлын хэсэг дээр санал, дүгнэлт гарсан байж байгаа.

3 талт хэлэлцээр боловсролын салбар дээр 23-аас 26 онд хэрэгжих хэлэлцээр байж байгаа. Тэгээд энийг үе шаттайгаар, тодорхой цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлаа салбарын түвшиндээ ярилцана гэсэн ийм хэлэлцээр явж

байгаа. Тэгэхээр боловсролын үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай энэ салбарын хэлэлцээрийн хүрээнд төсөв хэлэлцэхээс өмнө нэлээн олон удаа ажлын хэсгийн түвшинд уулзаж, ярилцаж, асуудлаа тодруулж явж байгаа гэж товчхон мэдээлэл өгье.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Энэ Сангийн яам, Хөдөлмөрийн яам нь 2 өөр тоо хэлээд байх юм. Сая юу гэххэв эмч нарын дундаж цалин 3,6-аас 4 сая байгаа гээд нэг юм хэлэх юм. Нөгөө талд нь болохоор 2,4 байгаа гээд 2 өөр тоо хэлээд байна. Боловсролын салбар 2,4 сая гээд дундаж нь тийм үү? Тийм учраас боловсролын салбар чинь ер нь багш нарын үндсэн цалинг ядаж нэг улсын дунджид хүргэххээч л гэсэн ийм саналыг тавиад байгаа юм байна лээ шүү дээ. Улсын дундаж үндсэн цалин Статистикийн хорооноос аваад үзэхэд 2,4 сая хавьцаа байна гэдэг юм гаргаж ирсэн үндсэн цалин шүү. Одоо бол 1 сая 400 хавьцаа байгаа тийм үү багш нарын цалин.

Дараагийнх нь эрүүл мэндийн салбар дээр ингэхийгээд болох болов уу гэдэг байдал биш. Эрүүл мэндийн салбарын чинь сан чинь ерөөсөө дийлэхээ больчихоод байгаа эсхүл цалингаа өгөөд эм, тариагаа хасах уу, эсхүл иймэрхүү байдалтай тулаад ирчихсэн байж байгаа. Дээрээс нь нөгөө хулгай гэдэг шиг нэг хэдэн эмнэлгүүдэд давуу байдлаар баахан мөнгө хуваарилчихсан энэ тэр гээд юм байгаа. Тэгээд энэ тал дээр яг тодорхой нэг санал хэлээч гэдгээ хэлмээр байна.

О.Номинчимэг: Сангийн яам энэ тоонуудынхаа зөрөөнүүд нь яг юу юм, байр суурь нь яагаад адилхан биш байгаа юм гэдэг дээр. Эхлээд 6 номер.

П.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Тэгэхээр түрүүний ярьсан тэр 3,6 сая гэдэг энэ нөгөө бүх нэмэгдэл, нэмэгдэл хөлс, илүү цаг, нөхөх төлбөрүүд орсон байдлаар ер нь 10-аас дээш жил ажилласан эмчийн цалин байгаа юм улсын дунджаар гарсан. Энэ бол Сангийн яамны энэ цалингийн хөлсний нэгдсэн системээс гарсан ийм тоо баримт.

Эрүүл мэндийн даатгалын өөрөө энэ чинь нөгөө тодорхой хэмжээний орлоготой, тэгээд жилд үзүүлдэг тусламж, үйлчилгээний хэмжээ ч гэсэн ингээд яг нэг ойролцоо 2, 3 жилийн хувьд ингээд дээш, доошоо хэлбэлзэл аягүй багатай учраас энэ маш нарийн тооцоолол дээр явагдах ёстой зүйл. Гэтэл одоо эмнэлгүүд энэ зардал тал дээрээ ерөнхийдөө илүү их анхаарч, зардлын хяналтаа сайн тавьж явахгүй бол энэ өрнөөс салахгүй. Санхүүжилтийг нь мянга нэмээд энэ асуудлаас гарч чадахгүй гэж Засгийн газраас үзэж байгаа. Тийм учраас энэ дээр эмнэлгүүдийн зардал тал дээр.../минут дуусав/

О.Номинчимэг: 4 номер Гэр бүл, хөгжлийн яам.

Б.Алимаа: Миний түрүүний хэлсэн статистик бол би түрүүн дурдсан, тодруулж хэлсэн. Энэ нөгөө салбарын дундаж гэдэг ойлголт. Боловсролын салбарт зөвхөн багшлах боловсон хүчнээс гадна харуул манай гэх мэтчилний, төрийн үйлчилгээний нярав нягтлангуудаас авхуулаад төрийн үйлчилгээний бусад албан хаагчдын цалингийн дундаж нэмэгдэж давхар орж байгаа шүү гэдгийг тодруулж хэлэх гэсэн юм. Энэ Үндэсний статистикийн хорооноос улирал болгон гаргадаг цалингийн статистик мэдээллээс хэлсэн тоо юм.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Боловсролын салбар дээр тэр тавиад байгаа шаардлагыг нь аваад үзэхээр тэр цалинг 3,5 сая гэж байгаа шүү дээ үндсэн цалин. Тэгээд энийг тавихад хэдэн төгрөг шаардлагатай юм бэ? Эрүүл мэндийн салбараас тавиад байгаа бас юу нь хэдэн төгрөг шаардлагатай юм бэ? Сая тэр Сангийн яамны хэлж байгаагаар тэгж байгаад дотор нь зардлаа хасахгүйгээр ер нь бол бүтэхгүй гэдэг ийм ерөнхий ийм дүгнэлт байж болохгүй. Мөнгө болгон чинь цаанаа үйлчилгээ л байгаа байх. Би яах вэ тэр хувийн эмнэлгийн бүх эмнэлгүүд ингээд мөнгийг нь авч, идэж уучихсан гэдэг юм би бол тийм юмыг тэгж бодохгүй байна. Тодорхой хэмжээний ачаалал үүрч байгаа. Тийм учраас Сангийн яам өөрөө яг үнэндээ эрүүл мэндийн салбарын төсвийг бариад сууж байгаа шүү дээ. Тэгэхээр эрүүл мэндийн салбар, боловсролын салбар дээр яг хэчнээн төгрөгийг төсөв дээр тавих боломж, бололцоо байгаа юм бэ? Зүгээр байхгүй, цалин нэмэхгүй, болохгүй гэдэг яг хэний байр суурь юм бэ? Сангийн сайдын байр суурь юм уу? Энийг чинь хэн нэгэн гаргасан байж таарна шүү дээ. Төрийн албан хаагчийн цалинг нэмэхгүй байя гэдэг ийм байр суурь яг хэний байр суурь юм бэ?

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Энэ байр суурийг яг өмнөөс нь хариулчих хүн байна уу? Тийм, тийм юм байхгүй байх шиг байна. Юу ч гэсэн 6 номер Сангийн яам.

П.Бат-Эрдэнэ: Засгийн газраас төсвийн төслийг 7 дугаар сарын 25-нд төсвийн ерөнхийлөн захирагчдаас саналыг хүлээж авснаас хойш боловсруулж эхлээд Засгийн газрын хуралдаанаар 3 удаа хэлэлцүүлээд, тэгээд нэгтгээд, Их Хуралд өргөн барьсан байгаа. 2026 оны төсвийн төсөлд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэх ийм зарлагын эх үүсвэр боломжгүй учраас энэ жилдээ цалин хөлс нэмэхгүй гэдэг бол Засгийн газрын байр суурь байгаа нэгдсэн.

О.Номинчимэг: Засгийн газрын байр сууриа? Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Өргөдлийн байнгын хороогоор иргэний үл хөдлөх хөрөнгөө зарахад улсаас авдаг 2 хувийн татвар, одоо эмч, багш нарын цалинг нэмэх тухай асуудлыг ярьж байгаа байхгүй юу. Нэг ч сайд байхгүй, энэ хэдэн мэргэжилтнүүд чинь ямар ч шийдвэр гаргахгүй. Энэ хүмүүс өнөөдөр Сангийн сайдын байр суурь юм уу, Боловсролын сайдын байр суурь юм уу, Засгийн газрын байр суурь гэж шууд хэлэхэд жижигдэнэ. Улсын Их Хурлын бүтцийн байгууллага Байнгын хороо хуралдаж байхад нохой хуцсаны дайтай нэг ч сайд нь ирэхгүй. Тэгсэн хэр нь энэ чинь нийгмийн хамгийн том асуудал шүү дээ. Эмч, багш нарын цалинг нэмэх үү яах вэ гэдэг асуудлыг хэлэлцэж байхад нэг ч сайд байхгүй. Бид өнөөдөр энд домоглож, худлаа тойрч суугаад, яриад, энэ хэдэн мэргэжилтнүүд бүлтэлзээд, очоод сайддаа загнуулна аягүй бол буруу яриад. Эсвэл сошиалд сэвэгдээд бөөн доромжлол амсана.

Тэгэхээр би Байнгын хорооны даргад ийм санал гаргаж байна. Сайд нарыг дуудъя, горимын санал. Миний энэ санал дээр санал хурааж өгөөч. Бид өнөөдөр энд худлаа ярьж, Өргөдлийн байнгын хороо нэг их асуудал шийдэх гээд ч байгаа юм шиг, үгүй ч юм шиг байх ямар ч шаардлага байхгүй. Тэгэхээр горимын санал гаргаж байна. Сайд нарыг дуудаж, асуудлыг дахин хэлэлцэх дээр санал хурааж өгөөч.

О.Номинчимэг: Харин тийм. Би ч гэсэн адилхан санал, байр суурьтай байна. Энэ хэлтсийн дарга, мэргэжилтнүүдээсээ бид юугаа ч яах вэ дээ, энэ чинь ийм төсөвтэй холбоотой, нийгмийн бодлоготой холбоотой асуудал ярьж байхад. Тэгэхээр горимын санал Мөнхбаясгалан гишүүн болохоор сайд нарыг одоо дуудах уу, эсвэл жоохон хойшлуулаад, одоо дуудах уу, эсвэл энэ долоо хоногийн дахиад 3 дахь, 4 дэхэд хуралдаад? Тэгвэл энэ санал хураахаас өмнө сайд луу нэг яриадахъя тэгэх үү? Тийм. Сайд луу яриадах эхлээд түр. Мөнхбаясгалан гишүүн горимын санал гаргах уу? Тэгье, Мөнхбаясгалан гишүүний микрофоныг өгье.

Л.Мөнхбаясгалан: Нийгмийн анхаарлыг татсан, маш олон хүний цахимаар санал гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, 2 хувийн татварыг байхгүй болгох, эмч, багш нарын цалинг нэмэх талаар гаргасан санал өнөөдөр Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцэгдэж байна. Гэтэл энд нэг ч сайд байхгүй. Энийг өнөөдөр Монгол даяараа харж байгаа. Тийм учраас горимын санал гаргаад, сайдуудыг оролцуулан дахин энэ асуудлыг хойшлуулж байгаад хэлэлцүүлж өгнө үү хэмээн горимын санал гаргаж байна. Энэ горимын санал дээр санал хурааж өгнө үү.

О.Номинчимэг: Эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар Ажлын хэсэг байгуулах нийтийн өргөдлийн энэ асуудлыг хойшлуулж, сайдууд болон Төрийн нарийн бичгийн дарга нарыг байлцуулан хэлэлцье гэсэн горимын санал Мөнхбаясгалан гишүүн гаргаж байна. Тэгэхээр санал хураалтад бэлдье. Саяын горимын саналаар санал хураалт. Нийт 11 гишүүн дэмжиж, 68,8 хувиар горимын санал дэмжигдлээ. Ийм учраас эмч, багш нарын цалинг нэмье гэсэн асуудлаар Ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдлийг хэлэлцэх асуудлыг хойшлуулж, Даргын дэргэдэх зөвлөл дээр санал тавьсны үндсэн дээр энэ долоо хоногт, мөн ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг гишүүдээс санал гарсан учраас хэлэлцүүлэн, тов дараалалд санал өгье.

15.59 цаг

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА